

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН  
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2026 оны 5 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-45

---

- 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 5-37
  - 2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох** 37-45
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын  
05 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 51.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, Л.Мөнхбаясгалан, Г.Уянгахишиг, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Т.Аубакир, Х.Ганхуяг, Б.Пунсалмаа, Да.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт М.Мандхай, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын талаарх илгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Н.Алтанхуяг, Х.Болормаа, М.Мандхай, М.Энхцэцэг, Б.Заяабал, Г.Очирбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн

яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Пүрэвдаваа, М.Мандхай, Ж.Батсуурь, Ж.Энхбаяр, Г.Очирбат, Г.Ганбаатар, Ж.Золжаргал, Д.Жаргалсайхан, Л.Гантөмөр, Р.Сэддорж нар үг хэлэв.

**Н.Наранбаатар:** 1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20  
Татгалзсан: 19  
Бүгд: 39  
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Наранбаатар:** Дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 17  
Бүгд: 39  
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, ахлах зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх мэдээллийг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Бадамсүрэн, Д.Жаргалсайхан, Б.Жавхлан, Р.Батболд нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 13 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Хамтарсан хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 29 минут үргэлжилж, 56 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Н.Наранбаатар:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 51,8 хувьтай бүрдсэн тул 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна. Ирсэн гишүүдийг танилцуулъя. Норовын Алтанхуяг, Жадамбаагийн Баясгалан, Нанзадын Наранбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Дашцэрэнгийн Энхтүвшин, Отгоншарын Батнайрамдал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Эрдэнэбилэгийн Одбаяр, Агваанлувсангийн Ундраа, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Ренчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Чинбатын Номин, Ганзоригийн Тэмүүлэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Нацагдоржийн Батсүмбэрэл, Ганзоригийн Лувсанжамц, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Болдын Уянга, Мөнхчулууны Энхцэцэг, Жамбын Батсуурь, Хүрэлбаатарын Булгантуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Банзрагчийн Түвшин, Цэндийн Баатархүү, Шинэбаярын Бямбасүрэн, Мэндбаярын Мандхай, Ренчинбямбын Сэддорж, Саруулсайханы Цэнгүүн, Жигжидийн Батжаргал нарын гишүүд ирсэн байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар Сангийн сайдын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Тийм 2 асуудал. Саналтай гишүүн байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дэх асуудал.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга.

Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Эдийн засгийн, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдыг урьж байна. 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг та бүхэнд танилцуулж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын эдийн засгийн орчин тогтворгүй, өндөр хэлбэлзэлтэй байж, тодорхойгүй байдал нэмэгдсээр байна. Геополитикийн хурцадмал байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, олон улсын санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал нь манай улсын эдийн засаг, төсвийн орлогод нөлөөлж эхлээд байна. Ялангуяа гадаад зах зээл дэх үнийн өсөлт, нийлүүлэлтийн эрсдэл нь дотоодын инфляц болон өрхийн хэрэглээний зардалд дарамт учруулах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ийм нөхцөлд Засгийн газар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилтыг тэргүүн ээлжид тавин ажиллаж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь улсын төсвийн орлогын 20 орчим хувийг бүрдүүлдэг төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах суурь, чухал эх үүсвэрийн 1 бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татварын орлого тогтвортой өсөж, 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6,2 их наяд төгрөгт хүрсэн байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бага орлоготой өрхүүдэд илүү өндөр хувьтай буцаан олголт олгох шаталсан тогтолцоог үе шаттай нэвтрүүлэхээр тусгасан. Уг зохицуулалт нь иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулах зорилготой байсан хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн орлогын эрсдэлийг харгалзан үзэх шаардлага үүсээд байна.

Олон улсын байгууллагуудын макро эдийн засгийн үнэлгээ, зөвлөмжид татварын орлогыг огцом бууруулах бодлого нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийг хязгаарлах, улмаар эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэж болзошгүйг онцлон дүгнэсэн. Иймд Засгийн газар эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, төсвийн тогтвортой байдлыг харгалзан НӨАТ-ын урамшууллын буцаан олголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хүчингүй болгож, одоогийн мөрдөж байгаа 20 хүртэл хувийн буцаан олголтын зохицуулалтыг хэвээр хадгалахаар энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Ингэснээр төсвийн орлогын тогтвортой байдлыг хамгаалах, инфляцын дарамтыг нэмэгдүүлэхгүй байх, макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах, дунд хугацааны хөгжлийн санхүүжилтийн чадавхыг хадгалах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсвийн тодотголыг өргөн мэдүүлэх хугацаатай холбоотой хэт хатуу зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгалаа. Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал маш богино хугацаанд өөрчлөгдөж байгаа энэ үед төсвийн бодлогыг цаг алдалгүй уян хатан хэрэгжүүлэх шаардлага нэмэгдэж байна. Гэвч хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш 3 сарын хугацаанд төсвийн тодотгол өргөн мэдүүлэхийг хориглосон нь бодлогын шуурхай арга хэмжээг цаг алдалгүй авах боломжийг хязгаарлаж байна. Иймд уг хугацааны хязгаарлалтаас төсвийн тодотголтой холбоотой зохицуулалтыг хасаж, эдийн засгийн бодит нөхцөлд нийцүүлэн төсвийн бодлогыг илүү уян хатан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгалаа.

Энэхүү өөрчлөлтөөр төсвийн сахилга бат сулрах бус харин эдийн засгийн гэнэтийн өөрчлөлтөд төсвийн бодлого шуурхай хариу үзүүлэх, орлого зарлагын тэнцвэрт байдалд үүссэн эрсдэлийг цаг тухайд нь зохицуулах, төсвийн удирдлагын үр нөлөөг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм шүүд ээ,

Засгийн газар эдгээр хуулийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн бодит нөхцөл байдал, төсвийн тогтвортой байдал, олон улсын байгууллагын зөвлөмж, иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг цогцоор нь харгалзан үзсэн болно.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд баярлалаа. Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Заяабал гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Энэ төсвийн төсөөлөл дээр хэрвээ төрийн өмчийн компаниуд Засгийн газрын 50-аас дээш хувийг нь эзэмшиж байгаа төрийн өмчийн

компаниудын өрийг оруулж тооцвол дотоодын нийт хөрөнгөд эзлэх хувь нь хэд болох вэ. Тэр талаар тооцоолол байгаа юу.

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд хариулъя. 5 номерын микрофоныг өгөөрэй.

**Ж.Энхбаяр:** Төсвийн хүрээнд зөвхөн Засгийн газрын өрийн хэмжээ тусгагддаг хуулийн тусгай шаардлагатай. Төрийн өмчийн компаниудын орлого, авлага, алдагдлын тоо хэмжээ, гадаад өр зээлийн асуудал энд орохгүй байгаа юм. Ер нь тооцоо хэд байна гэвэл бид нар тооцоод, танд удахгүй хэлээдэхье.

**Н.Наранбаатар:** Соронзонболд гишүүн тодруулъя. Соронзонболд гишүүний микрофоныг өгөөрэй.

**Л.Соронзонболд:** Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам чинь Монгол Улсын эдийн засгийг яаж цааш нь хөгжүүлэх вэ гэдэг бодлогын ажил илүү хийх ёстой. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр иймэрхүү тоо бол бэлэн байх ёстой л гэж бодож байна. Тэгэхээр энэ тоонд хариулмаар байна.

Дээрээс нь болохоор бид нар нөгөө Үндэсний баялгийн сан дотор Хуримтлалын сан гэж байгаа. Хуримтлалын сангийн холбогдолтой төрийн өмчийн компаниудын ногдол ашгууд орж ирэх ёстой. Тэгэхээр тэрний тооцооллыг яаж хийж байна. Ирэх 2 жилийн төсөөлөл дээр. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан гэж байгаа шүү дээ. Тэр чинь төрийн өмчийн компаниудын ногдол ашгаар бүрдэж байгаа. Тэгээд тэрийг яаж тооцохыг төсөөлж байна вэ гэж асуулт.

**Н.Наранбаатар:** 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Төрийн өмчийн компаниудын орж байгаа ноогдол ашиг төсвийн хүрээнд орохгүй. Намар төсөвтэй хамт өргөн баригдаж, төсвийн үед хэлэлцэгдэнэ. Төсвийн хүрээнд энэ онд орох ноогдол ашгийн тооцоо ордоггүй гэж.

**Н.Наранбаатар:** Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ дагасан хууль дээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах гээд ороод ирж байгаа юм. Бид нар чинь ер нь ард түмний нуруун дээрээс татварын ачааллыг бууруулъя гэдгээсээ бас ухралт хийгээд байгаа юм биш үү. Энэ 15.2.1-ийг уг нь шатлалтай байсан зүйлийг л авч хаяад, 20 хүртэл хувиар буцаан олгоно гэсэн зүйл ороод байх шиг байна. Тэгээд хойшоогоо ер нь ухраад байна уу даа гэдэг л зүйл харагдаад байна. Энэ шатлалыг нь бууруулснаар ер нь хэчнээн хэмжээний төсөв гэдэг юм уу хэмнэгдэх гээд байгаа юм. Энэ дээр нэг тооцоолол байна уу. Бүр нөгөө шатлалтай байсныгаа бүр хугацаагүй аваад хаячхаж байгаа юм уу. Эсвэл эргээд энэ нь бас шатлалаараа орж ирэх ийм хугацаа байгаа юм уу. Тооцоолсон юм байгаа юм уу гэдэг 1 дүгээр асуудал байна.

2 дугаарт нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах гэж орж ирж байгаа. Энэ хугацааны хувьд л гэж ойлгоод байгаа. 3 сарын дотор тодотгол хийж болохгүй гэсэн заалтыг авч хаях гээд байгаа юм болов уу гэж. Ер нь бид нар чинь төсөв хэлэлцэх гэж 6 сар, 7 сарын 1 гэхэд яамд нь цуглуулаад л тэрийгээ базаж базаж, 10 сарын 1 гэхэд Их Хуралд өргөн барихаар ингээд 2, 3 сар явдаг. Тэгэхээр энийг авч хаяад ер нь 3 сарын дотор тийм тодотгол хийх боломж нь байдаг юм уу гэж асуумаар байна.

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төсвийн орлогын 20 орчим хувийг бүрдүүлж байгаа НӨАТ манай 4 суурь орлогын 1 төсвийн орлого. 2025 оны гүйцэтгэлээр 6,2 их наяд төгрөг орж байгаа. Дотоодын бараа дээр 2,8 их наяд, гадаад импортын бараан дээр 3,9 бараг 4 их наядын НӨАТ-ын орлого бүрдэж байна. Ерөөсөө НӨАТ-ын орлого бүрдэж байгаа 2 эх сурвалж энэ. Бид 20 хувийг нь буцаан олголтыг өгдөг ийм хууль, эрх зүйн орчин мөрдөж байгаа. Одоо энийг нэмэгдүүлэх 50 хувь шатлалтай болохоор ингэж оруулж ирсэн. Яг өнөөдрийн бодит байдал, гадаад орчны өөрчлөлттэй холбоотойгоор төсвийн тэнцэл өнөөгийн байдлаар 1,4 их наядын хасахтай явна. Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээ 1 их наяд. Одоо бид 400 тэрбум нэмчихсэн алдаж явна. Тэгэхээр үлдэж байгаа хугацаанд энийг бид нар нөхөж ч чадахгүй.

Дээрээс нь энэ хууль хэрэгжээд эхэлбэл бид нар 1,6-1,8 их наядын нэмэлт зардлыг энэ НӨАТ дээр гарна гэсэн үг. НӨАТ-ын орлого буцаад 1,6-1,8 их наядар багасна. Тэгэнгүүт төсөв дээр байгаа 2,2 их наядын бид нарт хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зай үлдсэн. 2,2 их наядар бид нар үргэлжилж байгаа төсөл хөтөлбөрүүдээ санхүүжүүлээд, 2027 онд шинээр 1 ч төсөл хөтөлбөр оруулж ирэх бололцоогүй байгаа. Хэрвээ энэ 1,6-1,8 их наядын зардал ахиад нэмэгдэх юм бол ирэх онд шилжиж байгаа хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхгүй гэсэн үг. Үндсэндээ Монгол Улсын төсөв урсгал зардал, цалин, хүүхдийн мөнгө тэтгэмж энийгээ олгодог ийм л төсөв болж хувирна. Хөгжлийн ямар нэгэн хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоогүй болно л гэсэн үг.

Үндсэндээ бодит орлогоо тооцоогүй их зардлыг баталсан. Урсгал зардлын хэмжээ өнөөдөр нийт төсвийн чинь 80 хувь хэтэрчихсэн явж байна. Үлдэж байгаа 20 хувьд нь гадаад өр, зээл, төлбөр гээд хөрөнгө оруулалтын маш бага хэмжээтэй. Үүнээсээ ахиад үлдсэн тэр 2,2 их наядыг л ахиад 1,8-ыг нь ахиад зардал болгоно. НӨАТ-ын буцаан олголт болгоно гээд ийм шийдвэр хүчин төгөлдөр үргэлжлэх юм бол хөрөнгө оруулалт хөгжлийн асуудал орхигдоно л гэсэн үг. Ийм учраас энийг хүчингүй болгоё. Тодорхой хугацаанд эдийн засгаа бэхжүүлэх, ахиад эдийн засгаа томруулсны дараа энэ халамжийнхаа, тэтгэмжийнхээ бусад бодлогуудаа хэрэгжүүлж болно биз. Одоохондоо яагаад ч төсвийн бодит эдийн засгийн маань чадавх хүрэхгүй байгаа. Хэт орлогоосоо давсан зардлаа бид Их Хурал хуульчлаад баталсан. Ялангуяа багш, эмч нарын цалин, тэтгэврийн нэмэгдлүүд, тэтгэвэр инфляцтай холбоотойгоор ахиад нэмэгдэнэ. Багаар бодоход 10 хувиар тооцож нэмэгдэнэ. Тэрний зардлууд орж ирнэ. Дээрээс нь энэ дээр НӨАТ-ын буцаан олголт 1,8 их наяд гээд дийлэхгүй.

**Н.Наранбаатар:** Алтанхуяг гишүүн асуулт асууна.

**Н.Алтанхуяг:** Өглөөний мэнд. Надад 3 асуулт байна.

1 дүгээрт Сангийн яам энэ жилийн 2026 оны орлогын төлөвлөгөө ямархуу байдалтай явж байгаа вэ. Тасалдаж байгаа бол юугаар нөхөж яваа юм. Оны өмнө урьдчилгаа татвар гэж аж ахуйн нэгжүүдээс бас авсан гээд байх юм. Энэ үнэн, худлыг тодорхой хэлээд өгөөч.

2 дугаар асуулт. Сангийн сайд байхгүй юм уу. Хэн нь хариулах юм. Засгийн газар л хариулах байх. Би бас Сангийн сайд байсан хүн байхгүй юу. Та нар энэ төсвийн тодотгол гэдэг юмыг ийм ойрхон ойрхон хийхээр хуулиа өөрчилж оруулж ирж байгаа чинь буруу. Харин ч бүр жилдээ огт өөрчлөлт хийхгүйгээр гарвал арай

гайгүй байдаг юм. Ямар практик манайд байдаг вэ гэхээр энэ жилийн хувьд хэцүү байх шиг байна. Ер нь бол төсвийн орлого бол дандаа Сангийн яамны зовлон учраас бага төлөвлөдөг. Тэгээд давж биелдэг. Намар тэгээд тэр зөрүү хэсгийг нь алж иддэг Их Хурал ийм л тодотгол гэдэг нэрээр ийм практиктай байхгүй юу. Тэгсэн чинь одоо та нар ингээд 3 сарын дотор тодотгол оруулж ирэхгүй шүү гэхээр нь тэр заалтыг алга болгож байгааг буруу гэж үзэж байгаа юм. Тэр дээр яагаад тэгээд зүтгээд байгаа юм бэ.

Дэлгэрсайхан дарга Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга. Би танай дүгнэлтийг зөвлөмжийг бол нэлээн сайн уншсан юм. Та өөрөө нэг сайн тайлбарлаадхаач. Та нар бол маш их үнэтэй санал гаргаад байгаа юм. Засгийн газар тэрнээс ерөөсөө авдаггүй. Тэгээд л өөрийнхөөрөө зүтгүүлээд ингээд манай улсын төсвийн тогтвортой байдал гэдэг юм бол Засгийн газар оруулж ирэх бүхэнд л тогтворгүй болоод байгаа юм. Та энэ 2027 оны төсөв, тэгээд тэрийг дагаад төсвийн хүрээний мэдэгдэл дээр ямар өөрчлөлт гарч байгааг энэ олон нийтэд тодруун хэлээд өгөөч. Ийм 3 асуулт байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Сангийн яам Санжаадорж 3 номер.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Төсвийн орлогын нөхцөл байдал бол эхний 4 сарын гүйцэтгэл өчигдөр гарсан байгаа. Гүйцэтгэл нийт орлого бол 10,2 их наяд орсон. Гарсан зарлага бол 10,3, тэнцвэржүүлсэн орлого үүнээсээ 8,9 их наяд төгрөг байна. Ингээд алдагдал бол 1,4 их наядын алдагдалтай байна. Төсвийн орлого дээр бол бид нар тооцоо хийгээд үзэхлээр 3 зүйл хамгийн өндрөөр нөлөөлж байна.

1 дүгээрт бол нүүрсний үнэ нөлөөлж байна. Орлого дээр.

2 дугаарт хэмжээ нь нөлөөлж байна.

3 дугаарт импорт нөлөөлж байна. Үнийн хувьд бол өнгөрсөн жилийн эцсээр 64 доллар байсан бол одоогийн байдлаар 65 доллар гээд 1 долларын өсөлттэй байна. Тэгэхдээ үнэ бол бидний тооцсон 70 долларт бол арай хүрэхгүй байгаад байна.

2 дахь асуудал хэмжээ бид нарын хувьд тооцсон хэмжээнээс хавьгүй өндөр байна. Одоогийн байдлаар бол 42 сая тонн гараад явж байна. Энэ нь эхний 4 сараар бодох юм бол сардаа 10 сая тонн гарчихсан гэсэн үг. Оны эцсээр бол энэ байдлаар явах юм бол дор хаяж 100 сая тонн хүрэх боломжтой гэж харж байна. Тэгэхээр бид нар үнэ болон хэмжээний хувьд боломжийн хэмжээний, үнэ дээр бага зэрэг алж байна. Нөгөө талдаа импорт бол ноднингийн яг өдийд байсан хэмжээнд бол импортын хэмжээ явж байна. Гэхдээ бид нарын тооцоолсон импорт бол эндээс жаахан өндөр байгаа. Одоо бол идэвхжилийн үе нь одоо эхэлнэ. Бүтээн байгуулалтын үе. Тэгэхээр бүтээн байгуулалтын үе эхэлж байгаатай холбоотойгоор бол импорт нэмэгдэнэ гэж харж байна. Тэгэхээр орлого бол жилийн яг нийт хэмжээний төлөвлөгөөнөөсөө 28 хувь бол орсон байна. Өмнөх 5 жилийн гүйцэтгэлээр нь бид нар хараад үзэхэд ойролцоогоор 29 хувь орчим орж байсан байна. 1 хувийн тасалдалтай байна. Тэгэхээр орлого талдаа бид нар проблем бол гайгүй. Харин зарлага маань нэлээд асуудалтай болчихоод байна.

Зарлага яаж байна гэхээр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, халамж гэдэг маань маневрлах боломжгүй зардал. Цэвэр 12-т хуваагаад л сар болгон санхүүжүүлэх болчихоод байгаа юм. Тэгэхээр орлого орж ирж байна уу, үгүй юу гэдгээс үл хамаараад манай орлого маань бол өөрөө улирлын чанартай байдаг. Тэрнээс үл хамаараад зарлага маань жигд хуваагдах ийм тогтмол зарлагууд болчихоод байгаад байгаа нь алдагдлын хэмжээ бол өсөж байна. 7 сарын үеэр бол бид нарын тооцож байгаагаар бол алдагдал буураад 1 их наядаас доошоо 800 орчим тэрбум дээр орж ирэх болов уу гэсэн тооцоолол байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Тогтвортой байдлын зөвлөлөөс асуусан. 6 номерын микрофон.

**Ж.Дэлгэрсайхан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2-3 зүйлд гол анхаарлаа хандуулж, дүгнэлтээ өгөөд байгаа.

1 дүгээрт нь макро эдийн засгийн нөхцөл байдалтай нийцсэн төсвийн бодлого байгаа эсэх дээр бид анхаарч байгаа. Энэ дээр бол ахиц дэвшил гарсан байна гэж бид дүгнэж байгаа. Төсвийн зарлага бууруулах бодлогыг хэвээр хадгалж байна. Гэхдээ 2027 оны зарлагыг 10 орчим хувиар өсгөж байгаа нь өмнөх жилүүдийн буурч явсан өсөлтөөс ихэссэн байна шүү гэдгийг анхааруулж байгаа. Тэгээд 2028, 2029 онд бол энэ зарлагын өсөлтийн бодлогоо бууруулж байгаа, хязгаарлаж байгааг бол бид дэмжиж байгаа.

2 дугаарт нь макро эдийн засгийн орчны эрсдэлд байгаад байгаа энэ эдийн засгийн өсөлтийн тоо, бусад тоонууд нь манай зөвлөл болон олон улсын байгууллагуудтай нийцтэй байгаа боловч макро эдийн засгийн эрсдэлүүдийг бид нар их сайн харгалзан үзэх ёстой гэдэг ийм дүгнэлтийг өгч байгаа.

3 дугаарт нь бид нарын таны асуугаад байгаа гол өөрчлөлт бол тоонуудын өөрчлөлт гэхээсээ илүү түрүүний тэр дагалдах хуультай холбоотой өөрчлөлт дээр.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Гүйцээж хариулъя.

**Ж.Дэлгэрсайхан:** 3 сарын асуудлыг бид нар бас л энэ 3 сар гэдэг заалт дөнгөж түрүү жил үйлчилж эхлээд ингээд эхнээсээ бас яг үйлчлэлийг нь хойшлуулаад л яваад байгаа юм л даа. Энийг бол бид нар төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн тодотгохгүй сайн төсвийн төлөвлөлт рүү чиглүүлсэн сайн заалт гэж үзэж байгаа учраас энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хувьд бол энэ заалтыг бас их өөрчлөх нь буруу юм гэсэн ийм зүйлийг өгч байна.

Дараагийн бид нарын гол дүгнэлт бол төсвийн тогтвортой байдлыг хадгалахын тулд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр байгаа энэ тэнцвэржүүлсэн үнэ, төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд болон төсвийн хүрээний мэдэгдлийг тогтвортой байлгах энэ хууль, эрх зүйн орчныг чангатгах шаардлагатай юм байна. Тэгэхгүй бол дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл бодлогын хэв шинжээ алдаад байна гэсэн ийм л дүгнэлтийг бид голчлон өгсөн байгаа. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд хариулна. Дараа нь тодруулна.

**Ж.Энхбаяр:** Одоо энэ эдийн засгийн нөхцөл байдал маш богино хугацаанд их хурдтай өөрчлөгдөөд байна. Дэлхий нийтээрээ л хариу арга хэмжээнүүдийг янз янзын хувилбаруудыг л авч байна. Хэрэгжүүлж байна. Тэгэхээр төсвийн хүрээ 5 сарын 1-нд хуулиар өргөн баригдаад, 6 сарын эхэнд батлагдана. Үүнээс хойш 3 сарын хугацаанд хөдөлгөхгүй, хатуу цоожилчих юм болоод байна л даа. Тэгээд 9 сарын 1-ээс тодотгол шаардлагатай өргөн барих эрх үүснэ. Тэгэхээр энэ яг үүсэж байгаа нөхцөл байдал, төсвийн тэнцэл алдагдалтай байж байгаа байдал, шатахууны үнийн өсөлт 5 сарын сүүл, 6 сар, 7 сар бодитой орж ирнэ. Ачааллууд орж ирнэ гэсэн үг. Гадаад валют нөөц дээр ч эрсдэл гарна, инфляц дээр ч эрсдэл гарна. Иймд төсвөө яаралтай тодотгоод засаг илүү хурдан шуурхай хариу арга хэмжээгээ л бэлдье гэж байгаа юм. Ингэхгүйгээр энэ чинь төсөв батлагдангуут дагаж төсвийн хүрээ өөрчлөгдөх асуудал биш шүү дээ. Тодотгол дээр зөвхөн өөрчлөх эрх, тодотгол өргөн барих шаардлага, тусгай шаардлага үүссэн бол.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Алтанхуяг гишүүн тодруулна.

**Н.Алтанхуяг:** Ингээд л өөрсдийнхөөрөө зүтгэдэг хүмүүс л дээ. Та нартай ч юу ярих вэ. Санжаадоржоо, би их тодорхой юм асуусан. Чи битгий ийм урт үлгэр ярь л даа. Чи энэ олон нийтэд шүү 1 дүгээрт 4 сарын эцсийн байдлаар төсөв маань аль зэрэг тасарчхаад явж байгаа юм бэ. Хэчнээн их наядаар. Энийг хаанаас та нар нөхөөд, түр ингэж аргалаад явж байгаа юм бэ. 3 дахь нь би урьдчилгаа татварын урьдчилгаанууд авсан юм уу. Хаанаас хэчнээн юм авсан юм бэ. Нийлбэр нь хэд юм бэ. Ийм 3 юм хэлээд өг л дөө.

**Н.Наранбаатар:** 3 номер.

**М.Санжаадорж:** Санжаадорж Сангийн яам. Төлөвлөгөө, гүйцэтгэл 2-ын зөрүү бол эхний 4 сарын байдлаар 1 их наядын тасалдалтай явж байна. Зөвхөн орлого тал нь. Орлого 1 их наяд төгрөгөөр тасалдалтай явж байна. Төлөвлөгөө, гүйцэтгэл 2-ын зөрүү.

2 дугаарт ноднин бол 2025 оны эцсээр бол бас орлого хүндрээд, зарлага санхүүжүүлэх зайлшгүй шаардлагатай зардлууд гарч ирсэн. Цалин хөлс, тэтгэвэр гээд. Үүнтэй холбоотойгоор татварын урьдчилгаа бас 1 их наяд төгрөгөөр бол урагш нь татаж авсан. Тэгээд зарцуулсан. Одоо бол бид нар ингэж байна. Түрүүн яриад байгаа нь бол төсөвт нөлөөлж байгаа 3 хүчин зүйл байна. Хамгийн өндрөөр төсвийн орлогод нөлөөлж байгаа. Тэгэхээр нүүрсний хэмжээ бол гайгүй явж байна. Энэ хэмжээгээр бол бид нар 400-500 тэрбум төгрөг бол нэмэгдэх байгаа харагдаж байна. Оны эцсээр. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр.

**Н.Наранбаатар:** Болормаа гишүүн асуулт асууя.

**Х.Болормаа:** Сайн байцгаана уу. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бид өнөөдөр ирэх 3 жилийн Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн өсөлт, инфляц, улсын төсвийн төсөөлөл, төсвийн хязгаарууд буюу макро эдийн засгийн асуудлыг бол хэлэлцэж байна. Гэтэл бодит байдал дээр өнөөдөр иргэдийн амьдралд макро эдийн засаг бол эдийн засгийн өсөлтийн өөдрөг төсөөлөл, улсын төсвийн үзүүлэлтүүд бол огт хамаагүй болчхоод байна. Тэгээд би үүнийг бол бас жишээ дээр авч хэлье гэж бодож байна. Иргэдэд өнөөдөр ер нь юу хамаатай байна вэ гэхээр ерөөсөө л иргэдийн хөргөгчид өдөр тутмын амьдралд 1кг махыг хэдэн төгрөгөөр

авах вэ гэдэг асуудал хамгийн гол чухал асуудал болоод байгааг та бүхэн бол бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр бид нар энэ том том тоонууд тавиад, төсөөллүүдийг тавиад байгаа нь үнэхээр өнөөдрийн энэ бодит амьдрал дээр нийцэхгүй байна гэдгийг би бол бас шүүмжлэлтэйгээр хандаж хэлье. Жишээ нь би та бүхэнд нэг бодит жишээ хэлье л дээ. 2025 оны 5 сард дизель түлш 3040 байсан байна. Гэтэл өнөөдөр буюу 2026 оны 3 сарын байдлаар дизель түлш 1 литр нь 4335 буюу ноднингийн мөн үеийнхээс 38,1 хувиар өссөн байна. Тэгэхдээ энэ 3 сарын тоо шүү. Гэтэл өнөөдөр бид нар 5 сард талдаа ороод явж байна. Одоо улс орны байдал, дайн дажинтай холбоотой нефть буюу нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой маш олон хямралууд улс орон даяар бий болчихсон байж байхад 3 жилийн энэ төсвийн төсөөлөл буюу инфляцын энэ түвшнийг яаж, ямар тооцооллоор бодоод ингэж оруулж ирэв гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт та бүгдийн энэ ном дээр байгаа төсвийн төсөөлөл дээр байгаа мэдээллээр 2026 оны 3 сарын байдлаар инфляцын түвшин тоог бол авч үзсэн байгаа. Гэтэл өнөөдөр Үндэсний статистикийн хорооны мэдээллээр буюу 4 сарын 30-ны байдлаар инфляц 10,1 хувьд хүрч, энэ дотроо хүнсний инфляц 19,7 хувь болсон байна. Хамгийн ноцтой нь мах махан бүтээгдэхүүний үнэ 36,5 хувь.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Эхлээд хариулчхаад, дараа нь тодруулчихъя. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Болормаа гишүүн яг бодит байдлыг хөндөж байгаа юм. Инфляц нэлээн өндөр гарч байгаа. Ялангуяа манай суурь зардал 100 хувь үндсэндээ шатах, тослох материал импортоор авч байна. Хөдөө аж ахуйн гол онцгой том орц болсон бордоо 100 хувь авч байна. Уул уурхайн гол түүхий эд болсон тэсрэх бодис 100 хувь импортоор авч байна гээд импорт нэлээн өндөр байгаа. Энийгээ дагаад гадаад орчны аюулгүй байдлын орчинд үүссэн нөхцөлтэй холбоотойгоор үнийн энэ өсөлтүүд явж байна. Инфляцыг тооцоход 430 төрлийн бараа дээр сагсны бараа гэж аваад, энэ дотроо дундаж өсөлтөө гаргаад, инфляц гарч байгаа. Энэ жилийн тухайд бол 2026 оны 6, 7, 8 сар инфляц нэлээн өндөр 2 оронтой тоогоос дээш гарна. Энэ дотроо хүнсний инфляц их өндөр байгаа. 1 дүгээрт мах байна, 2 дугаарт ногоо байна, 3 дугаарт гурил, улаан буудай гэсэн ийм нөлөөлөл гарч байна.

Харьцангуй энэ 3 нөлөөллийг бид дотоодын зах зээлээсээ зохион байгуулаад, дотооддоо тогтворжуулах ерөнхий суурь боломж, чадавх бидэнд байгаа. Энэ хаврын тариалалт дээр Засгийн газар онцгой анхаарсан. Бордоо, ургамал хамгааллын бодис, шатах, тослох материалыг бид өвлийн нөөц буюу үнэ өсөөгүй үеийн үнээрээ хангалт хийж, тариалалтыг явуулсан. Энд бол бордоо ургамал хамгааллын бодис мөн өвлийн татсан үнээрээ буюу үнэ нэмэгдээгүй үнээр явсан. Уул уурхайн салбарт бол яг нөлөөлөл орж байна. Уул уурхайн ашигт ажиллагаа дээр 20-оос доошгүй шатахууны нөлөөллүүд ороод ирж байна. Бусад импортоор дамжих нөлөөллүүд байна. Эм, бусад хүнс, өргөн хэрэглээний бараа дээр нөлөөлөл гарна. Тэгээд ийм учраас л бид энэ тодотгол хийх орон зайгаа засагт байж авъя. 3 сар гэж өөрсдийгөө хүлэхгүйгээр хурдтай түргэн юм огцом өөрчлөгдөхийн цаг үед зохион байгуулалттай арга хэмжээ авъя. Зарим төсөл хөтөлбөрөө хойшлуулъя. Өнөөдрийн нийгмийн тулгамдаад байгаа чиглэл рүүгээ гол хүчээ хаяхад, тодотгол хийхэд энэ дагасан хууль их чухал байна. 6 сарын 1-нд Их Хурал төсвийн хүрээгээ баталлаа. Засаг тодотгол өгнө. Тэгвэл наадмаас өмнө тодотголоо хийгээд, тохиргоогоо хийгээд явчихмаар байна. Тэгэхгүй бол 2025 оны төсөв 2026 ондоо

үргэлжлээд, яг ийм маягаар бол 2026 оны төсвөө дуусгахгүй, 2027 ондоо давж үргэлжлэх царайтай. Сая чинь 2025 онд 2026 оноосоо 1 их наядыг авч байж давж гарч байна шүү дээ. Тэгэхээр энэ санхүүгийн жилийг санхүүгийн жилд нь дуусгаад, таслаад таслаад цэгцлэхгүй бол бас үргэлжилсэн ийм ужиг юм руу явах гээд байна.

2 дугаарт энэ инфляцтай холбоотой зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээнүүд авах хэрэгтэй байна. Тэгэхээр дунд хугацаандаа өсөөд, намар ургац боломжийн, тариалалт эвтэйхэн явахад энэ өвөлжилт эвтэйхэн, хаваржилт, эвтэйхэн, мал төллөлт их сайн байна. Аяндаа махны нийлүүлэлт дотоодоосоо буугаад байх зохицуулалт сайтай. Харьцангуй гайгүй. Мах, ногоо, гурилан бүтээгдэхүүнийг барьчих байх.

**Н.Наранбаатар:** Болормаа гишүүн тодруулъя.

**Х.Болормаа:** Би энэ дээр бүр яг өнөөдөр тулгамдаад байгаа 1 асуудлыг л яг ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ гэдгийг би асуумаар байна. Махны үнийн өсөлт бага орлоготой иргэдэд буюу өрхүүдэд хамгийн хүнд тусаж байна. Тэгэхээр энэ дээр Засгийн газар ойрын хугацаанд ямар арга хэмжээ авч ажиллах вэ. Энэ дээр хариулт өгөөч.

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** 2 үзүүртэй юм болчихоод байгаа юм л даа. Нэг талаасаа хөдөө аж ахуйн мал махны экспортыг бүх талаар дэмжиж байгаа. Сүүлийн 3 жил 300 сая доллароос дээш хэмжээний экспорт хийдэг болсон. Уул уурхайн 5 бүтээгдэхүүн дээр нэмэх нь мах, ноолуур хоёр 300-аас дээш болж орж ирж байгаа. Энэ бол хөдөөгийн малчдын орлого, мал аж ахуйн эрхэлж байгаа талдаа тун таатай буюу ашигт ажиллагаа нэмэгдээд, хөдөөгийн өрхийн орлого нэмэгдэхэд гол суурь нөлөөлөл мах, ноолуурын үнэ өсөөд байдаг. Ороод байдаг. Хот суурин газар дээрээ махны үнийн өсөлт орлогод бас нөлөөлөөд сөрөг тусаад байгаа. Ер нь засаг дээр яригдаж байгаа нэг зүйл бол 2 арга хэмжээ байгаа.

1 дүгээрт бол орон нутаг өөрөө нөөц бэлдэх үндсэн үүрэгтэй. Аймгийн дарга, нийслэлийн засаг дарга нар өөрсдөө бэлдэж байгаа. Засгийн газраас аль болох энэ нийлүүлэлтэд оролцохгүй байх бодлогоо барина. Зах зээлийн эрэлт нийлүүлэлтээрээ ингээд зохицоод, зохистой харьцаандаа очъё гэж байгаа.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Тодруулах уу Болормаа гишүүн. 1 минут нэмээд өгчихье. гүйцээгээд хариулчих. 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр өнгөрсөн намар нийслэлд 8 мянга орчим тонн нөөцийн мах бэлдсэн. Энийгээ энэ хавар нийлүүлээд, үндсэндээ энэ 5 сард нийлүүлээд дуусна. Үүнээс цааш ямар нэгэн арга хэмжээ авахгүй. Үнэ барих бодлогод оролцохгүй. Энэ ер нь тийм зохистой биш. Нийт улсын хэмжээнд бодлого зохицуулж чадахгүйгээс хойш энэ зах зээлд нь нийцүүлээд, мал аж ахуйгаа улам эрчимжүүлэх, хөгжүүлэх, тасралтгүй байдлыг нь хангаад дэмжээд л тэр талдаа явах нь зохистой байх болов уу л гэж бодож байна.

Яагаад гэвэл махны нийлүүлэлт, махны үнийн цаана маш олон аж ахуйн нэгж, олон бизнесийн суурь харилцаанууд хөндөгдөөд байгаа. Тэгэхээр аль болох зах зээлд нь нийцүүлье. Эрэлт нийлүүлэлт нь тэр хуульд нь нийцүүлье л гэж бодож

байна. Тэгэхээр засгаас ямар нэг үнэ хямдруулах, ямар нэгэн зохицуулалттай арга хэмжээ авахгүй.

**Н.Наранбаатар:** Очирбат гишүүнийг асуултын дараалалд нэмж оруулаарай. Мандхай гишүүн асуулт асууна.

**М.Мандхай:** 2027 оны төсвийн хүрээг харахад 36,5 их наядын зарлагатай, орлого нь 34,8 их наяд гэж байгаа. Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт бол ер нь бодитой гэж би бол харж байгаа. Бараг тэдний дүгнэлтийг бол ер нь дэмжиж ярих ёстой байх. 1 дүгээрт энэ төлөвлөгөө бол өөрөө төсвийн хүрээний мэдэгдэл. Төлөвлөгөө бол өөрөө маш өөдрөг төсөөлөл болсон. Тэгээд ер нь бол ингээд засаг солигдохоор л геополитик яриад л нэг бол Ойрх Дорнод бензин шатахуун хүндэрлээ, дизелийн хомсдол үүслээ гээд нэг талаараа айлгаад байдаг. Тэгээд тэгвэл бүсээ чангалаад эдийн засгаа бид нар бас нэлээн ухаалгаар шийдэхгүй бол болохгүй юм байна гээд төлөвлөгөөгөө оруулаад ирэхээр тэс хөндлөн ийм төлөвлөгөө дандаа орж ирдэг. Тэгээд ингээд сайдын ярьж байгааг сонсохоор төлөвлөсөн, ярьж байгаа 2-ын юмнууд нь ингээд зөрөөд байгаад байдаг. Яг үнэнээ хэлэхэд та сая хөдөө аж ахуйг ярилаа. Одоо энэ инфляцын асуудал хүндэрснээс болоод жилийн инфляц өнгөрсөн оны 12 сар гэхэд 7,5 хувьтай байсан. Өдөр ирэх тусам түлш, мах, бараа бүтээгдэхүүний чинь үнэ тасралтгүй нэмэгдээд байна. Ингээд харахаар 12 сар гэхэд ер нь бид нар 12 сарын сүүл гэхэд энэ бараг 2 оронтой тоо руу очих түвшинд ирчихсэн байгаа. Тэгэхээр энэ яагаад хөдөө аж ахуйн энэ махны үнэ сая Болормаа гишүүний хэлээд байгаа үнэ нэмэгдээд байгаа юм бэ гэхээр инфляц өндөр учраас үнийн хөөсрөлтөөр дамжиж малчдын орлого өссөн болохоос биш бодит орлогын өсөлт бол ерөөсөө үүсээгүй. Одоо хэдүүлээ төлөвлөгөөгөө ярихдаа ингэж ярьдаг болмоор байна. Яг тогтвортой хэдэн ажлын байр яг би нэмэгдүүлсэн юм бэ. Ядуурлын түвшнийг бид нар хэдээр бууруулсан юм бэ. Малчдын амьжиргааг нэмэгдүүлэх энэ бодлого байсан уу. Тэгвэл хэдээр нэмэгдсэн юм гэдэг ийм бодитой, амьдралд хөрсөн дээр буусан төлөвлөгөө ярихгүй бол сүүлийн 30 жил ард иргэдийгээ айлгасан, тэгсэн мөртөө төлөвлөгөө нь орж ирэхээрээ дандаа алдагдалтай ингээд ерөөсөө нөгөө баахан үр ашиггүй зардлуудыг бий болгочоод, тэгээд төлөвлөгөө, гүйцэтгэл нь ингээд 1 их наядын зөрүү үүсчихсэн гэдгийг яриад суугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ярьж байгаа, орж ирж байгаа төлөвлөгөө, ярьж байгаа юм чинь ерөөсөө хоорондоо нийцэж ажиллахгүй байгаад байна.

2 дугаарт энэ чөлөөлөлт үндэсний үр дүн 2-ыг харьцуулж хармаар байна. Бид нар 2026-2030 онд 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан. Энэ дээр 8 чиглэлийг тусгасан байгаа. 2027 онд болохоор 4 чөлөөлөлт гээд энэ 8 чиглэлийн яг алинтай нь уялдаад байгаа нь бас ийм ойлгомжгүй юм яваад байх юм. Тэгээд энэ дээр яг ямар үр дүн дээр түшиглэж энэ үндэснийхээ үр дүнг шинээр оруулж ирж байгаа чөлөөлөлттэй уялдаж байгаа юм бэ. Эндээс чинь хамаараад төсөвт суулгаж байгаа төсөв, хэрэгжүүлэх гэж байгаа төсөл хөтөлбөр бүх энэ зарлага чинь өөрөө уялдаж.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Хэн хариулах вэ. 5 номер Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Төсвийн хүрээнд энэ чөлөөлөлт буюу Засгийн газрын жилийн зорилт бол хамаагүй шүү дээ. Төсвийн хүрээ буюу хуульд заасан макро эдийн засгийн 9 үзүүлэлтээ л бүгдээрээ тойрч ярина шүү дээ. Орлого, зарлага, гадаад өр, төлбөрөө ярина. Тэгэхээр таны асуулт жоохон ойлгогдохгүй болоод байна.

Нөгөө талдаа инфляц бодитой байгаа. Энэ дэлхий нийтийн л асуудал тулчхаад байна шүү дээ. Бүгд мэдэж байгаа. Монгол Улсын хамгийн сул тал шатахуунаас 100 хувь хамааралтай байна. Энийгээ хамаарлаа бууруулахын тулд бид нар Алтанширээ Нефть боловсруулах үйлдвэрийн ажлын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж байна. Харамсалтай нь сая Гадаад зээлийн ашиглалтын хуультай холбоотой сая Их Хурлаас дэмжлэг авахгүй, уначихлаа. Дахин өргөн барьж байгаа. Шатахуунаа ямар ч байсан хамаарлаа багасгая, эрчим хүчээ хамаарлаа багасгая гэдэг тэргүүлэх 2 том зорилт байна шүү дээ.

3 дугаарт хүнсний хангамжийн асуудал. Ер нь дэлхийн бүх улс орнууд эрчим хүч, шатахуун, хүнс гэдэг дээр л төвлөрч байна. Тэгэхээр хүнсний хангамжаа нэмэгдүүлэхийн тулд энэ атар газрыг нэмэх, ашиглах, хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх, хаврын тариалалтыг өргөн хэмжээнд зохион байгуулах ажлуудыг л засаг зохион байгуулалт, арга хэмжээ аваад явж байна. Харин энэ шатах тослох материал тасалдуулахгүй байх дээр 1 дүгээрт зорилт амжилттай явж байна. 2 дугаарт бид нар үнийг урт хугацаанд гэрээлээд тогтвортой байдлыг хангах асуудлуудыг Дамдинням сайд бараг 5, 6 удаа явж хөөцөлдөж байж ард нь гараад ирлээ. Тэгэхээр нийлүүлэлт дээр алдаа байхгүй. Хомсдохгүй. Гол нь үнийн өсөлтийг бид нар яагаад ч энд бол хариу арга хэмжээ авах бололцоо байхгүй. 2 дугаарт бидэнд тийм дотоод чадавх байхгүй. Энд татаас өгөөд байх бололцоо алга байна. Цалин, тэтгэвэр, халамжаасаа илүү гарч чадахгүй болчихоод байна шүү дээ.

**Н.Наранбаатар:** Мандхай гишүүн тодруулна.

**М.Мандхай:** Тэгэхээр Энхбаяр сайд аа, эдийн засгийн өсөлт, инфляц, төсвийн орлого, зарлагын дээд хэмжээ зэргийг бол мэдээж энэ төсвийн хүрээний мэдэгдлээр бол тодорхойлсон. Гэхдээ үзүүлэлтийн энэ төсөөлөл бол 2027 оны улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тооцоолж байгаа Засгийн газрын бодлого шүү дээ. Засгийн газрын бодлого буюу энэ чөлөөлье гээд орж ирж байгаа энэ зорилтууд чинь өөрөө энэ бодлого нь өөрөө үндэсний үр дүн буюу 2027 оны чинь төлөвлөгөөтэй уялдахгүй юм уу. Би бүр сайн ойлгохгүй байгаад байх юм. Энэнтэй чинь уялдаж энэ төлөвлөгөөнүүд чинь гарч байгаа биз дээ.

Дээрээс нь энэ миний үг бас биш. Энэ мэргэжлийн төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргаж байгаа. 1 дүгээрт энэ төлөвлөгөө бол ерөөсөө смарт биш байна гэдгийг тодорхойлоод гаргачихсан. Ер нь бид нар хүрээгээ тодорхойлохдоо хүртэл үргэлж л орлогоо өөдрөгөөр төсөөлж, тэрэнд нь энэ хүрээгээ тооцож ирсэн. Санхүүжилтийн ямар ч эх үүсвэр .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** 5 номерын микрофон.

**Ж.Энхбаяр:** Энэ эдийн засгийн өсөлтийг Засгийн газар ингэж өөдрөг тооцоод байгаа юм биш шүү дээ. Бодит манай эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд ер нь 5-7 хувийн хооронд байнгын л энэ түвшнээ хадгалж чадаж байгаа. Олон улсын валютын сан манайхыг 5,3 хувь өснө гэж тооцсон байна. Дэлхийн банк 5,5 гэж тооцсон байна. АХБ 6 хувь гэж тооцсон. Бид Монголын Засгийн газар 5,8 хувь гэж тооцсон. Энд тооцохын тулд бүх л Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүх үзүүлэлтүүдийг л авч үзэж тооцож гаргаж байгаа шүү дээ. Өөдрөг байх буюу энэ потенциал 6 хувиа хадгалчих хэмжээнд байна.

1 дүгээрт нүүрс олборлолт бол нэмэгдэхээр байна. Хил холболтын төмөр замууд ашиглалтад орно. Экспорт бас боломжийн. Биржийн арилжааг явуулсантай холбоотойгоор бирж дээр үнэ эвтэйхэн тогтчихдог болсон байна. Төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэнэ, тээвэрлэлт нэмэгдэнэ. Зэс болон төмрийн үнэ гол .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Одоо 1 минут байгаа. Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Тэгэхээр ийм байгаа юм. Одоо зөвлөлөөс гаргасан бас тайлан мэдээн дээр нь бас байсан. Макро эдийн засгийн талаар дүгнэхдээ өсөлтийн голлох хувийг үйлчилгээний салбар, тэр дундаа бөөний болон жижиглэн худалдаа эзлэхээр байна гэж дүгнэсэн байгаа. 2026 оны эдийн засгийн өсөлтийг 6-7 хувьтай байхаар төсөөлснөөс үүний 50 хувь нь тус салбараас байгаа гэж тооцсон байгаад байгаа юм. Энэ тооцоолол нийтдээ ДНБ-ий өсөлтийг бид нар үндэслэлгүй тооцсон гэж үзэж байгаа. Бид нар бөөний болон жижиглэнгийн худалдаанаас хэрэв өсөлт үзсэн юм бол яаж бид нар ДНБ-ий өсөлтийг өөрөө зөв тооцсон гэж үзэх гээд байгаа юм. Хэрэв эдийн засаг бөөний, жижиглэн худалдаанаас үүдэлтэй юм бол ДНБ бид нар өндөр байх нөхцөл ерөөсөө бүрдэхгүй. Яагаад гэхээр үнэ цэн шингээхгүй байгаа байхгүй юу. Энэ чинь валю гэж юм байхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхлээр ерөөсөө энэ төлөвлөгөө өөрөө маш учир дутагдалтай байгаа юм. Бид нар энэ тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, аудитын дүгнэлтийг бол бид нар маш сайн энэ .../минут дуусав/.

**Н.Наранбаатар:** Өнөөдөр бол төсвийн хүрээ ярьж байгаа. Жилийн төлөвлөгөө бол тусдаа Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдэнэ. Тэгэхдээ хариулъя. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Түрүүн хэлснийх дээр хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрүүд үргэлжилнэ. Ган, зэс боловсруулах энэ томоохон бүтээн байгуулалтын ажлууд явагдана. Нефть боловсруулах, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын бүтээн байгуулалтууд явагдана. Энэ Баян болон Бөөрөлжүүт, ТЭЦ-5, Тавантолгой цахилгаан станц гээд төслүүд явагдана. Тэгэхээр ер нь бүтээн байгуулалтын ийм үе ерөөсөө зогсохгүй. Улам нэмэгдэнэ. Тийм болохоор 5-6 хувийн өсөлт гэдэг бол манай бодитой чадавх байхгүй юу даа. Боломж. Энийгээ л бид нар дээшлүүлж нэмэх, эдийн засгаа тэлэх л асуудал явна. Тэгэхээр энэ нэг их тийм өөдрөг зүйл биш. Нэг их өөдрөгөөр бодоод л байгаа юм биш. Бодитой. Хэрвээ энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас яаж бодож байгаа талаар та асуух хэрэгтэй байх. Ер нь бид нар байр суурь, тооцоо яг энэ дээр бол адил гарч байгаа. Ер нь эдийн засгийн 5,8 хувийг бол 2027 ондоо бид нар хангах нь. 2026 оны яг дунд хугацаанд гадаад орчинтой холбоотой нефтийн .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Тогтвортой байдлын зөвлөл хариулъя. 6 номер.

**Ж.Дэлгэрсайхан:** Тогтвортой байдлын зөвлөлөөс Мандхай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нарын хувьд манай төсвийн хүрээний мэдэгдлийн дүгнэлт дээр макро эдийн засгийн таамаглал, тооцоололдууд өмнөх жилүүдээсээ төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон олон улсын байгууллагуудын таамаглалтай ойролцоо болсон гэж дурдсан. Мандхай гишүүний хэлээд байгаа нь бид нар зүгээр дүгнэлтдээ 1 зүйлийг эдийн засгийн өсөлтийн эрсдэлийг харгалзаж найдвартай тогтвортой байдлыг нь баталгаажуулах ёстой гээд. Өмнөх жилүүдэд эдийн засгийн өсөлтийг хөдөө аж ахуй, уул уурхай болон бүтээгдэхүүний цэвэр татвараас үүсэн бий болж байсан байна. Энэ баримт бичиг дээр бол голчлон Коп-

17, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний салбараас хамаарна гэсэн энэ байдлаа яг хэрхэн нөлөөлөх вэ гэдэг нөлөөллийг нь илүү нарийвчилж харгалзаж, илүү тодорхой болгох ёстой гэсэн ийм үг, хэллэгийг хэрэглэсэн. Тэрийг Мандхай гишүүн хэлж байх шиг байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Энхцэцэг гишүүн асуулт асууя.

**М.Энхцэцэг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийдөө би манай улс маань ер нь төсвөө жаахан тааруухан төлөвлөдөг юм байна даа л гэж ингэж хардаг л даа. Тэгэхээр энийг нэлээн сайн төлөвлөхөд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол маш нэлээн үүрэг рольтой гэж хардаг. Дээрээс нь энэ зөвлөлөөс гаргаж байгаа зөвлөмжүүд ер нь бол нэлээн сайн ийм зөвлөмжүүд гарсан байдаг. Гэхдээ энэ зөвлөмжүүдийг Засгийн газар хэр ер нь авч хэрэгжүүлдэг юм бэ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ер нь өнгөрсөн онуудын Засгийн газрын гүйцэтгэл дээр үнэлгээ хийсэн тоо баримт байна уу. Та бүхний зүгээс нийтдээ юу гэдэг юм 10 зөвлөмж гаргасан, энэ 10 зөвлөмжийн 7, 8-ыг нь Засгийн газар хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлээгүй гэдэг ч юм уу ийм үнэлгээ хийсэн тоо баримт ер нь байна уу. Миний хараад байгаагаар энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөмжийг дагаад байвал бас нэлээн төсөв маань чамбайрах юм шиг харагддаг. Харамсалтай нь авахгүй байгаа юм шиг юм харагддаг.

2 дугаарт Төсвийн тогтвортой байдлын зөвлөмжийг заавал биелүүлэх ёстой гэсэн ийм хуулийн заалт байна уу. Хэрвээ байхгүй бол байлгах шаардлага байна уу.

3 дугаарт нь Ерөнхий сайд мэдэгдсэн. Улсад ажил хийсэн аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийг 3 хоногийн дотор олгодог болно гэж мэдэгдсэн. Харамсалтай нь өнөөдөр 2025 онд улсад ажил хийсэн маш олон аж ахуйн нэгжүүд санхүүжилтээ авч чадахгүй явж байна. Тэгэхээр энд тодорхой хариулт өгөх тоо баримт байна уу. Одоогийн байдлаар хэдэн аж ахуйн нэгжийн хэдэн тэрбум төгрөгийг та бүхэн 2025 оны гүйцэтгэлийг олгож чадахгүй явж байна. Тэгэхээр ингээд Ерөнхий сайдын хэлж байгаа, мэдэгдэж байгаа мэдэгдэл яг бодит байдал дээрээ зөрөөд байна. Тэгэхээр энэ дээр бас нэг хариу өгөөч ээ.

Дараагийн нэг асуудал бол өнгөрсөн онд төсвөө төлөвлөхдөө ард түмнээсээ асуулаа гээд маш том мэдэгдэл хийж байсан. Ард түмэн болохоор бид нар анхан шатны хэрэглээ буюу эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчиндээ л энэ төсвөө зарцуулаарай гэдэг захиасыг өгсөн. Бодит байдал дээрээ тэс ондоо байсан. Тэгэхээр энэ жил бас дахиад л нэг ийм асуудал үүсэх үү. Энэ дээр Тогтвортой байдлын зүгээс ямар зөвлөмжийг өгч байгаа вэ. Мөн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ жил урсгал зардлыг бууруулахын тулд ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүл гэсэн ийм зөвлөмжийг өгч байгаа вэ. Бид нарын харж байгаагаар бол үнэхээр төр бол данхар байгаа. Маш олон урсгал зардлыг бууруулах боломж зүгээр бид нарын нүдэн дээр бол харагдаад байгаа. Засгийн газар хэрэгжүүлэхгүй байгаа. Төсвийн тогтвортой байдлын зүгээс яг 1 дүгээрт нь ийм юм хэрэгжүүл, 2-т нь ийм юм хэрэгжүүл гэсэн тийм тодорхой өгсөн зөвлөмжүүд байна уу. Тэгэхээр бидний хувьд бол төсвөө оновчтой төсөвлөж байж л өнөөдөр улс орон тэргүүн ээлжийнхээ асуудлуудыг шийдээд цаашаа явна. Энэ дээр хариулт өгөөч гэж хүсэж байна.

**Н.Наранбаатар:** Хариулья 6 номер. Тогтвортой байдлын зөвлөл.

**Ж.Дэлгэрсайхан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа бол төсвийн тогтвортой байдлын хуулиар зохицуулагдаж байгаа. Бид нарын үйл ажиллагааны бүрэн эрх бол ерөөсөө дунд хугацааны макро эдийн засгийн төлөвлөлттэй холбоотой төсөөлөл, таамаглалаа боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яам болон холбогдох талуудад өгөх, Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төсөл, төсвийн тодотголын төслүүдэд дүгнэлт гаргах. Мөн тэдгээрийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах болон 2025 оны 7 сараас эхлээд хяналтын чиг төсвийн боловсруулалтын шатанд болон төсөв батлах, хэлэлцэх, батлах үйл явц дээр хяналтын ийм үүргийг гүйцэтгэж байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд дүгнэлт зөвлөмжүүдээ өгсөөр байгаа. Гэхдээ манай зөвлөлийн гол дүгнэлтүүд бол Улсын Их Хурал руу ч ихэвчлэн чиглэж гардаг. Бид нар бол Улсын Их Хурлыг дүгнэлт, зөвлөмж мэдээллээр хангах, үнэн зөв мэдээллийг Улсын Их Хуралд хүргэж, Улсын Их Хурал дээр төсөв болон хөгжлийн төлөвлөгөөний хэлэлцэх үйл явцад дэмжлэг үзүүлж байгаа ийм байгууллага.

Мөн Засгийн газар луу бид нарын дүгнэлт зөвлөмж бол төсвийг сайжруулахтай холбоотой байдаг учраас Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамд бол энэ дүгнэлт, зөвлөмжийг авч ашигладаг. Ашиглаж байгаа 2, 3 хэлбэр байгаа. Шууд ашиглах ёстой гэсэн ийм хууль байхгүй. Ганцхан ашиглах ёстой гэж заасан заалт нь бол макро эдийн засгийн төсөөлөл, таамаглал дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан төсөөлөл, таамаглалыг баримтлан, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулна гэж байгаа. Гэхдээ энийг бол яг ягштал баримтална гэсэн заалт байхгүй бөгөөд тэрхүү заалтыг баримтлаагүй бол тайлбарлах ийм зохицуулалттай явж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийнхаа хүрээнд явж байгаа. Бидний дүгнэлт, зөвлөмжийн хувьд тоо баримт хэлбэл зөвлөлийн хувьд ер нь дүгнэлт, зөвлөмжийг 2024 онд 9 удаа, 2025 онд 12 удаа, одоо 2026 он гарсаар бид 5 удаагийн дүгнэлт, зөвлөмжийг энэ холбогдох хууль тогтоомжийн төслүүд дээр гаргачхаад байж байна. Энэ дотроо бол бид нар маш олон дүгнэлтүүдийг өгдөг. Жишээ нь 2025, 2026 оны төсвийн төсөл дээр бид нар бол 47 дүгнэлт, зөвлөмжийг өгч, тэр дотроо болохгүй байгаа болон анхаарах зүйлс, сайжруулах шаардлагатай зүйлсийг дурдаж байсан. Дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа байдал дээр бол бид нар яг нарийвчилсан тийм юм гаргах боломжгүй юм гэж үзэж байгаа юм. Яг манайхыг ингээд тэрийг нь баримтлах ёстой, тэрийг нь баримтлаагүй бол тэгнэ гэсэн юм байхгүй. Дээрээс нь 90 хувь нь яг Улсын Их Хурал руу ирж байгаа дүгнэлт, зөвлөмж байгаа учраас бид дүгнэлт, зөвлөмж гаргаж, тэр дүгнэлт, зөвлөмжийг маань ашиглаж Улсын Их Хурал дээр хууль хэлэлцэх, батлах үйл явцад дэмжлэг болж байгаа. Бид нар өөрсдийн байр сууриа илэрхийлж байгаа гэж ойлгож байгаа.

Гэхдээ ер нь бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг баримтлах тийм заалт байхгүй ч гэсэн сүүлийн үед харин харьцангуй бидний дүгнэлт, зөвлөмжийг Их Хурлын гишүүд маань, Байнгын хороод маань болон Засгийн газар тодорхой хэмжээгээр тусгаж ажиллаж байгаа. Энэ нь бол дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийн баримт бичгүүдээс илт харагдаж байгаа. Сүүлийн жилүүдэд манай зөвлөлийн тусгасан дүгнэлт нь ийм байсан. Энийг ингэж төсөвтөө тусгалаа. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлдээ тусгалаа гэдэг ийм бүлэг хэсгүүд бол нэлээд сайжирсан байгаа гэж хэлмээр байна.

Мөн бидний гол бодлого болох төсвийн тогтвортой байдлыг хангуулахдаа хууль, эрх зүйн орчныг тогтвортой байлгах болон ДНБ-д эзлэх зарлагын хувь хэмжээг бууруулах бодлогыг бол Засгийн газар харьцангуй ойролцоогоор барьж явж байгаа. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулж байгаа энэ бодлого нь бол манай зөвлөмжтэй бол бид нар нийцтэй байна гэдгээр ер нь бидний дүгнэлт, зөвлөмжийг авч хэрэгжүүлж байгаа юм байна гэдэг ийм дүгнэлтийг өөртөө хийгээд, хувьдаа хийгээд явж байдаг гэсэн үг. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Эдийн засаг, хөгжлийн яам Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Ер нь макро эдийн засгийн тооцооллоо гаргахад ашиглаж байгаа эдийн засгийн загварчлал, бүртгэл, олон улсын стандарт адилхан байгаа шүү дээ. Зарим 1 тоон дээр зөрнө. Жишээлбэл, нүүрсний үнэ, биет хэмжээ, экспорт гээд ер нь сүүлийн 4 жилд 5,5-7 хувийн эдийн засгийн өсөлт хангана гэсэн зорилтыг Засгийн газар дэвшүүлсэн. Үндсэндээ энэ зорилтынхоо ард гарсан. Энэ зорилт гэдэг чинь бид нарын бас хүсэж тэмүүлэх зүйл. Гадна орчин харж байгаа шүү дээ. Монгол Улс өсөх нь үү, хөгжих нь үү, засаг нь ямар бодлого тавьж байна вэ гэж. Энийг бага болгоод ороод ирэх шиг амархан юм байхгүй. Энэ чинь улам зорилт тавьж, ахисан түвшний төлөө засаг өөрийгөө бас шахаж, Их Хурал нь бас засгаа шахаж, та нар илүү хурдан боломжоо дайчил, илүү сайн ажил гэдэг л даалгавар шүү дээ. Тэгэхээр энийг та нар энэ 5,8 хувь их өөдрөг байна гэж яриад байх нь хэр зөв юм бол доо. Харин ч 5,8 хувь бага. Улам дайчил, дээш нь өгсөг гэдэг л даалгавар өгч байж энэ засгаа шахаж байвал их зөв .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Тодруулъя Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжийн хувьд яах вэ, ер нь Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан ийм зөвлөмж гаргадаг. Яг Засгийн газрын зүгээс буюу Эдийн засгийн яам, Сангийн яам нь бол бас заавал хэрэгжүүлэх ийм хууль, эрх зүйн үндэс байхгүй гээд хэлж байна л даа. Гэхдээ зүгээр харж байхад энэ зөвлөмжийг сайн биелүүлбэл төсөв маань улам чамбайрах юм шиг харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хууль дүрэмдээ тэр өөрчлөлтөө шаардлагатай бол оруулаад, зөвхөн Улсын Их Хурлын гишүүдэд туслах зорилгоор мэдээлэл хангах биш, та бүхний тэр гаргасан зөвлөмж өнөөдөр дараагийн орж ирж байгаа тэр төсөв дээр чамбайраад, тусгагдаад ороод ирэх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ дээрээ алхам хийж ажиллаач ээ.

2 дугаар асуудал болохоор төсвийн тогтвортой байдлаас энэ жил урсгал зардлыг яаж бууруулах зөвлөмж өгсөн юм бэ. Тэрэнд хариулаач ээ. Тэр Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ 2025 онд ажил хийчхээд мөнгөө авч чадахгүй байгаа байгууллагууд ямар тоо баримт байна вэ. Тэрийг хэлээч гэсэн тэрэнд хариулаач.

**Н.Наранбаатар:** Энийг Сангийн яам уу. Сангийн яам хариулчих. Гүйцэтгэлтэй холбоотой. 2 номер. Мэндсайхан сайд.

**З.Мэндсайхан:** Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалттай санхүүжилт гацаж байгаа асуудал огт байхгүй. Ажлын 3 хоногт багтааж гарга гэдэг Ерөнхий сайд чиглэл өгсөн. Та [pimis.gov.mn](http://pimis.gov.mn) рүү ороод харах хэрэгтэй. Манай худалдан авалтын санхүүжилтийн асуудал маш нээлттэй, ил тод явдаг. Хамгийн хяналт өндөртэй ийм систем байгаа. Хэн дээр ямар материал хэдийд очсон, яаж санхүүжигдсэн, ямар үлдэгдэлтэй байгаа гэдэг нь хэн ч ороод харахад нээлттэй байгаа. Нийтдээ энэ жил 3,2 их наядын төсвийн хөрөнгө

оруулалтын ажил байгаа. Он гарснаас хойш 530 тэрбумын санхүүжилт явагдчихсан. Эндээс бол 286 тэрбум нь 2025 оноос шилжиж орж ирсэн энэ санхүүжилт аль хэдийн гараад явчихсан. Тэгэхээр та бол дутуу мэдээлэлтэй байна гэж ойлгож байна. Тэгэхээр та тэр [pimis.gov.mn](http://pimis.gov.mn) руу ороод шалгаад үзвэл таны бас эргэлзээтэй байгаа асуудлууд тэндээс тайлагдах байх. 2 дугаарт .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Гүйцээж хариулъя. 1 минут.

**З.Мэндсайхан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргаж байгаа зөвлөмжийг үндэслээд бид нар төсвөө төлөвлөөд явдаг. Энэ дээр мэдээж энэ зөвлөмжийг авдаг. Гэхдээ зөвлөмжийг заавал авна гэсэн ойлголт байхгүй. Яагаад гэхээр төсөв төсөвлөх эрх нь Засгийн газарт л зөвхөн байгаа. Засгийн газар төсвөө төсөвлөж, Улсын Их Хурлаар батлуулна. Энэ Үндсэн хуулиар олгогдсон зохицуулалт байгаа. Тэгэхээр хэрэв бид нар энийг заавал аваад явна гэх юм бол Засгийн газар төсөв төлөвлөх шаардлага байхгүй. Их Хурал төсвөө өөрсдөө төлөвлөөд, баталдаг ийм тогтолцоо руу ороод энэ Үндсэн хуулийн зөрчил рүү орно. Тэгэхээр энэ зөвлөмжийг бид нар авч ашиглаад, хоорондын хамтын ажиллагаагаа сайжруулаад явна уу гэхээс биш хуулиар энэ зөвлөмжийг ав гэдэг ийм ойлголт бол байж болохгүй.

**Н.Наранбаатар:** 5 номер нэмж хариулъя. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Энхцэцэг гишүүн ээ, төсвийн хүрээ оруулж ирэхийн тулд энэ чинь энэ өвөлжингөө л ажил болж байгаа. Монгол банкттайгаа, статистиктайгаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэйгөө хэд хэдэн уулзалт хийнэ. Эд нараасаа дүн тоогоо авна. Эргээд танилцуулна. Зөвшилцөнө, маргалдана, олон нийтийн хэлэлцүүлэг болно, бүх томоохон экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжүүдтэйгээ уулзана. Их олон ажил болж байж тэгээд сүүлдээ шинжлэх ухаан, олон нийтийн байгууллагын хэлэлцүүлгээ хийнэ. Тэгж байж өргөн барьж байгаа зүйл шүү дээ. Энэ бол улс төрийн асуудал биш. Ерөөсөө л манай Монгол Улсын потенциал чадавх маань ямар байна, бидний орлого ямар байна, зардлаа яаж аль түвшинд байх нь зохистой байна. Засгийн газрын өрөө яаж авч явах вэ, халамжийнхаа зардлын дээд хэмжээг яаж авч явах вэ гэсэн гол макро тоонуудаа л хийнэ. Тэгэхээр бид нарын уялдаа их сайжраад байгаа. Маш сайжирсан. Хамтын ажиллагаа их сайжирсан. Олон тоон дээр аргачлалуудтай нийлдэг болсон. Мэдээж мэргэжлийн эдийн засагч нарын хувьд бол зөрөх тоо баримтууд .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Нэг минут гүйцээе.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр гишүүд асуугаад байгаа юм. Та нар энэ төсвийн тогтвортой байдлын юман дээр хэр ажиллаж байна, сонсож байна. Маш сайн сонсож байгаа. Ер нь тэгээд та нар таамаглалууд, зөвлөмжийг харьцуулаад сүүлийн 3 юм уу 4 жилээр нь судлаад үзэхэд их сонин тоо гарна. Засгийн газрын тавьсан зорилт биелсэн байна уу, эсвэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөмж нь биелсэн байна уу гээд. Аль аль нь байгаа. Тэгэхээр энэ чинь аль аль нь мэргэжлийн мэтгэлцээн, мэргэжлийн бас давхар хяналт яваад байгаа байхгүй юу. Энэ систем бол засаг ингэж үзэж байна. Хөндлөнгөөс Их Хурлын дэргэдэх энэ Төсвийн тогтвортой зөвлөл гэж үзэж байна. Ингээд үр дүн гэж гарч байна. Үүний үр дүнд бол улам л төсөв чамбайраад, сахилга бат чамбайраад, төсвийн хүрээ чамбайраад, маш их өндөр ахицтай гарч байгаа шүү. Өмнөх өмнөх Их Хурлаасаа эрс өөрчлөгдөж байгаа зүйл. Энийгээ улам боловсронгуй болгоод хамтдаа цаашаа явах ёстой юм байгаа юм л даа.

**Н.Наранбаатар:** Заяабал гишүүн асуулт асууна.

**Б.Заяабал:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхлээр би 2 асуудал дээр анхаарлаа хандуулж, асуулт асууя. Тэгээд асуултаа Эдийн засаг, хөгжлийн яам болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хоёроос асууя гэж ингэж бодож байна.

1 дүгээр асуудал нь энэ инфляцтай холбоотой асуудал. Өнөөдөр бараг л гишүүн болгон л ирж байна. Эдийн засаг, хөгжлийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ макро эдийн засгийн төлөв байдал, судалгаа, анализ хийгээд оруулж ирж байгаа. Тэгээд энэ оруулж ирж байгаа энэ макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамгийн чухал асуудал нь инфляц. Инфляц юунаас болж өсөөд байна вэ гээд бензин шатахуун, тэгээд импортын барааны үнэ, дотоодын эрчим хүч, мах, хүнсний бараа энэ тэрээ гээд орон сууц, зээлийн хүү гээд өндөр байгаа. Ингээд л олон асуудлыг энэ инфляцын нөлөөлөлд авч үзэж болно. Инфляцын цаана хамгийн гол нь ард иргэдийн асуудал, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа энэ барааны үнийн өсөлт байна. Үүний чинь цаана иргэдийн хувьд иргэдийн бодит орлого чинь буурч байна.

Дээрээс нь бизнес эрхлэгчид чинь энэ инфляц өндөр болсонтой холбоотой Монголбанкны зүгээс хатуу бодлого авч явуулж байгаа. Одоо Монголбанкны мөнгөний бодлогын авах бодлого нь л тэр. Хатуу бодлого аваад явуулчхаж байгаа юм. Тэгэнгүүт нь бизнесүүд нь идэвхжилгүй болоод банкнаас зээл гарах нь багасаад, тэгээд чанаргүй зээлийн хэмжээ нь нэмэгдээд, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулаад зарагдах борлогдох асуудал чинь буураад эдийн засаг чинь бүхэлдээ ингээд идэвхжилгүй ийм нөхцөл байдал руу орж ирж байгаа юм. Энэ дотроо хамгийн гол энэ инфляцад нөлөөлөөд байгаа 30, 40 хувь нөлөөлөөд байгаа энэ махны асуудал байгаа. Тэгээд мах дээр бол манайх бол бэлтгэн нийлүүлэлтийн өнөөдөр систем байхгүй. Энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ инфляцыг тогтвортой байлгах үүднээс махны хувьд энэ логистикийг хангасан, сум, орон нутаг болгонд стандартын бойтой, бэлтгэн нийлүүлдэг олон улсад байдаг энэ Warehouse Financing гээд ийм системийг нэвтрүүлэх талаар ер нь ямар бодлого барьж байна гэдэг дээр 1 дүгээр асуулт асууя.

2 дугаарт нь зах зээлийг нэмэхтэй холбоотой асуудал бол Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн гол ажил. Евроазийн хэлэлцээрийг баталсан. Хэлэлцээр баталсан. Японы эдийн засгийн хэлэлцээрийн хажууд Евроазийн хэлэлцээр маш сайн хэлэлцээр болсон. Маш сайн хэлэлцээр болсон. Гэхдээ энийг амьдруулахтай холбоотой дэд бүтцийн асуудал чинь алга байна шүү дээ. Баруун бүсэд ялангуяа илүү идэвхтэй болно гэж үзэж байгаа. Евроазитай хамгийн ойрхон бүс нутаг нь баруун аймгууд. Өнөөдөр манай баруун аймаг бол бусад бүсүүдээсээ хамгийн бага орлоготой, хамгийн их ядууралтай ийм бүс. Тэгээд энийг яаж энэ зах зээлийг нь тэлэхтэй холбоотойгоор ямар арга хэмжээ авч явуулж байна. Баруун бүс рүү холбосон авто замын сүлжээ бас явахгүй байгаа нь үүний цаад дагалдаж явах ёстой бодлогууд нь дутагдаж байна л гэж би хараад байна л даа.

Узбекстан, Солонгостой бас энэ худалдааны гэрээ хийж байгаа юм байна. Тэр ажлынх нь явц нь ямар байгаа юм .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** 1 минут нэмж өгье. Тэгээд бид нар энэ зах зээлээ нэмж явахгүй бол эдийн засгийнхаа эрэлтийг нь бий болгож явахгүй бол энэ Монгол чинь эдийн засгийг солонгоруулна л гэнэ, бүсчилсэн хөгжлийн бодлого явуулна л гэнэ,

зах зээл байхгүй болохоор энэ чинь зүгээр л хоосон цаасан дээр үг болоод хоцорчлоод л байна шүү дээ. Тэгэхээр зах зээлийг нэмэхтэй холбоотой ямар бодлогыг та нар оруулж ирж байгаа юм бэ. Оруулж ирж байгаа энэ тооцоо, судалгаа чинь ерөөсөө байгаа хэдхэн нүүрс, зэс, алт, энээ тэрээ хэдэн компаниудын уулын ажлын төлөвлөгөө энэ дээр үндэслээд гаргаж ирсэн тоо мэдээ байгаад байх юм. Гэтэл Монгол Улсад уул уурхайн орон гэхэд 1800 ашиглалтын лиценз байгаа. Ашиглалтад эргэлтэд оруулж байгаа 250 лиценз байна шүү дээ. Үлдэж байгаа нь хаана байгаа юм. Хэн нэг нь цаас хэлбэрээр ха дараад суучихсан байгаад байдаг. Гэтэл энэ гаргаж байгаа экспортын чинь 95 хувь нь ганцхан орон тоо моно худалдан авагчтай. Тэгээд моно худалдан авагчтай болохоор яадаг вэ гэхээр зэрэг үнэ дээр бид нар нөлөөлөх боломж байдаггүй. Төр нь өөрөө зах зээлийн үнээр ингээд бүтээгдэхүүн дээр нь татвараа авъя гэхээр бид нар наад зах зээлийн үнээр чинь .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Хэн хариулах вэ. 5 номер уу. Эдийн засгийн, хөгжлийн сайд Энхбаяр хариулна.

**Ж.Энхбаяр:** Ерөөсөө инфляц дээр 2 л бараа, шатахуун, мах, хүнсний ногоо. Хүнсний ногоотой холбоотой ноднин төвийн бүсэд ургац алдсан. Ялангуяа төмс 80 хувь өссөн. Үндэс суурьт ургамлуудын үнэ нэлээн өндөр гарчихсан. Энийг бол бид нар дотоодоосоо хангах бололцоотой. Махан дээр ч гэсэн 1, 2 жил бүгдээрээ тэсээд л даваад л гарна. Аль болох л зохицуулалт хийхгүй, төрийн оролцохгүй байгаа зах зээлд нь энэ эрэлт нийлүүлэлт нь нийцүүлчихвэл зохистой хэмжээндээ энэ мах, ногоо оччих болов уу л гэж бодоод байна. Шатахуун дээр бол Засгийн газар арга хэмжээ авч байгаа. Гэрээ хэлэлцээр тогтвортой, үнээ баталгаажуулах нийт үл таслалтыг хангахгүй байх, стратегийн нөөц бүрдүүлэх сав суулга барих гээд энэ ажлууд хийгдэж байна.

Хөдөө аж ахуй, мал аж ахуйг авч гарах гол юм бол энэ Атрын 4 дүгээр аяны хүрээнд бид нар 200 мянган га талбайг эргэлтэд оруулж, тэжээлийн таримлыг нэмэгдүүлэх, малаа тэжээдэг болгох. Одоо та бүхэн анзаарсан бол сүүлийн 2 жил малын зүй бус хорогдол эрс багасаад эхэлчихсэн. Малаа тэжээдэг болчихсон. Дээрээс нь маш сайн ангилаад зах зээлд нь гаргадаг болчихсон. Туранхай, онд орохгүй бүх малчин намар бэлтгэгдээд экспортод валют болчихож байгаа юм. Тэр нь малчдын орлого болчихсон. Тэгээд дандаа төллөх эх малаа барьж үлдээд, тэгэхдээ тэжээдэг болчихсон. Энэ бол маш сайн өөрчлөлт явсан. Энэ өөрчлөлт 2, 3 жил үргэлжилнэ. Энийг жигдлээд, зах зээлийн горимдоо эрэлт нийлүүлэлтээр нийцтэл нь бид нар аль болох бага оролцоод, энэ тэжээлийн үйлдвэрлэл, тэжээлийн аж ахуй эрчимжүүлэх, газар ашиглах талд нь жоохон дэмжээд өгөхөд бол аяндаа шийдэгдчих болов уу л гэж бодогдож байна.

Узбек, Солонгостой 2 талын худалдааны хэлэлцээрүүдийг бэлдэж байна. Солонгостой одоо 5 дахь удаагийн түвшний хэлэлцээр лүүгээ орчихсон. Ер нь нэлээн дөхөж байна гэсэн үг. Узбектэй бол 2 талаас харилцан нэвтрүүлэх тарифын хөнгөлөлттэй бараануудаа солилцчихсон. Энэ бол Узбектэй ажил бол дөнгөж эхлэлийн шаттай. Евроазийн холбоотой хийсэн гэрээ үндсэндээ дууссан. Нөгөө гэрээнд оролцож байгаа 5 орны парламент баталсан. Хугацаа, тоолуур 7 сарын 1 гээд бараг гэрээ хүчин төгөлдөр болж эхэлнэ. Энд хөдөө аж ахуйн салбарын түүхий эдийг хөнгөн үйлдвэрээ, хүнсний үйлдвэрээ экспортод бэлдэж байна. Гэрээ, хэлэлцээр, техникийн тохирлын, мал эмнэлгийн, ургамал хорио цээрийн гээд гаалийн, татварын байгууллага стандартын байгууллага хоорондын тухайн улсуудын Евроазийн бүс нутагтаа тэр тохиргооны ажлуудыг Засгийн газрын

байгууллагууд нэлээн хийж байна. Аж ахуйн нэгжүүд маань ч бас сайн бэлдэж байгаа ийм ажлууд хийгдэж байгаа. Энэ бол нэлээн хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг эдийн засагт өсгөхөд, зах зээл тэлэхэд нь нэлээн том дэмжлэг болно гэж нэлээн итгэл найдвар тавьж байгаа. Тэгээд энийг нэлээн хариуцлагатай зохион байгуулж байгаа.

Ашигт малтмалын хууль АМНАТ-ийн хуулийг засгаар хэлэлцсэн. Өргөн барина. Яг үүгээр л орон нутгийн хөгжлийг дэмжсэн АМНАТ-ийн орлогын дийлэнх нь орон нутагтаа, сумдаа үлддэг. Сум хөрөнгө оруулалтыг татах сонирхол төрөх, дэмжих ийм хандлагыг үүсэх үүднээс хийж байгаа. Ашигт малтмалын хуульд бол зэс дээр нэлээн том анхаар, зэсийн АМНАТ-аас авхуулаад бодлогын өөрчлөлтүүд хийнэ. Манайд чинь 21 зэсийн орд нөөц тогтоогоод, ашиглаж чадахгүй сууж байна шүү дээ. АМНАТ-ийн 21 хувийн босготой хамаараад, энийг өөрчлөөд энэ зэсийн салбараа нэлээн сайн дэмжье. Хөрөнгө оруулалт татаж байгаа орон нутгийг үлдэх хөрөнгийг нь нэлээн сайн нэмэгдүүлнэ. Тэгэхээр энэ хууль 5 сардаа багтаад эдийн засгийн эрх чөлөөний, хөрөнгө оруулалтын, ашигт малтмалын, АМНАТ-ийн зөвшөөрлийн, Гадаад худалдааны, төр, иргэний, хяналтын гээд эдийн засгаа дэмжсэн хуулиудыг багцаар нь энэ 5, 6 сард засгаас оруулж ирнэ.

1 зүйл хэлэхэд манай эдийн засгийн чадавх үндсэндээ ханаж байгаа. Иймд бид нар эдийн засгаа тэлэх хэрэгтэй. Шинэ Тавантолгой, шинэ Оюутолгой, шинэ төмөр зам, шинэ станц бид нарт хэрэгтэй байгаа. Одоо байгаа эдийн засаг, төсөв бүрдүүлж байгаа эдийн засгийн маань чадавх үндсэндээ цалин хөлснөөсөө илүү гарахгүй хэмжээнд ингээд тулаад ирж байна шүү дээ. Тэгэхээр эдийн засгаа томруулж байж л, саваа томруулж байж л бид нар хөгжлийн хөтөлбөрүүдээ хангах, нийгмийн асуудлыг шийдэх бол .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Тогтвортой байдлын зөвлөл. 6 номер хариулна.

**Ж.Дэлгэрсайхан:** Заяабал гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Инфляцыг бол бид бас дүгнэлтдээ гол анхаарах зүйл гэж үзсэн. 2026 оны сүүлийн хагас, 2027 онд инфляцын өндөр түвшин хадгалагдах ийм нөлөөлөлтэй байна. Бидний өгч байгаа гол зөвлөмж бол сүүлийн жилүүдэд инфляц болон төсвийн зарлагын хоорондын хамаарал бол маш өндөр байна. Дээрээс нь урсгал зардлын дундаж хувь хэмжээ өндөр явсан нь инфляцад нөлөөтэй байна гэж үзэж байгаа.

Тийм учраас манай зүгээс өгч байгаа гол зөвлөмж бол төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг бууруулж байгаа. Энийг тодорхой хэмжээний үр ашигтай түвшинд аваачих, 30-аас доош тогтвортой хадгалах манай зөвлөлийн тооцож байгаа 27 хувь руу аваачих нь зүйтэй. Дээрээс нь сүүлд түрүү жилээс эхэлж бариад байгаа урсгал зардлын хэмжээ 24 хувь гэдэг ийм түвшнээ хадгалах ёстой.

Дараагийн нэг зүйл нь бол мөчлөг сөрсөн бодлогоо бид нар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ёстой юм. Учир нь өнөөдөр яг мөчлөг сөрсөн бодлого гээд ..../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Заяабал гишүүн тодруулъя.

**Б.Заяабал:** Тэгэхээр энэ саяын хариултуудаас надад бол үнэхээр хангалтгүй хариултууд байна. Би бол Статистикийн газрын даргыг дуудаж авчраад, асуулт асуугаагүй шүү дээ. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг өнгөрсөн 2, 3 жилд нь

дүгнэлт хийгээд, ирээдүйн 3 жилийг нь төлөвлөж байгаа ийм хүмүүс шүү дээ та нар. Төрийн бодлогын баримт бичиг боловсруулж байгаа. Тэгээд хариулж байгаа хариултууд чинь ямар хангалтгүй юм бэ. Үгүй ээ, би жишээлбэл зах зээлийг нэмэхтэй холбоотой баахан гэрээ байгуулаад байгаа юм бол тэр логистикийн асуудал дээр чинь очоод дахиад гэрээ чинь үр ашиг чинь унана л гэж би хэлээд байна шүү дээ. Тэгээд далайд гарцгүй цөөхөн орны хувьд олон улсын төмөр замын хэлэлцээрийн дагуу бид нар яаж зах зээлээ тэлэхтэй холбоотой ямар бодлого явуулж байгаа юм бэ. 1 дүгээрт. Би тийм л юм асуусан шүү дээ. Яаж зах зээлийг тэлэхтэй холбоотой. Одоо байгаа нүүрс, зэс, алт гэсэн хэдхэн юмнууд дээр, төмөр гэсэн хэдхэн юмнууд дээрээ тооцоод тэр хэдхэн дата дээр тооцоод ингээд ийм тоо гаргаад суугаад байх юм. Макро эдийн засгийнхаа тэр инфляц хамгийн гол үзүүлэлт чинь инфляц шүү дээ. Инфляцыг би бол.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Очирбат гишүүн. 2 удаа л тодруулна. Очирбат гишүүн асуулт асууна. Хариулъя. Хэн хариулах вэ. 5 номер.

**Ж.Энхбаяр:** Энэ экспортыг тэлэх логистикийн асуудал. Энэ Евроазийн гэрээтэй холбоотой дагаж хийгдэж байгаа л ажлууд л даа. Та сая махны логистик ярилаа. Бид нар сүүлийн 30 жил, жилдээ 10-20 сая долларын л мах гаргадаг байсан. Бүх Засгийн газар мах экспортолно гэж ярьдаг байсан. Харин сүүлийн жилүүдэд жилд 300 саяас буухаа больсон шүү дээ. Дэлхийн 17 оронд гардаг болсон, хүргэдэг болсон, очдог болсон. Энэ болгонд чинь л мал эмнэлгийн, хорио цээрийн, стандартын тээврийн, транзит дамжин өнгөрөх бүх гэрээ хэлэлцээрүүд зөвшөөрлүүдийг нь хийж байж очиж байгаа байхгүй юу даа. Тэрнээс үсрээд тэр мах чинь явахгүй шүү дээ. Ямар ч байсан манай мах бол энэ шинэ зах зээлд эрэлттэй, очдог болсон, нийлүүлэгддэг болсон. Ийм болохоор махны үнэ өсөж байгаа юм. Тэгэхээр энэ ажлууд бол хийгдэж байгаа л гэдгээ хэлэх гээд байгаа юм. Улам зах зээлээ нэмэхийн тулд бид нар 2 талын хэлэлцээр бүс нутгийн байгууллагуудын чөлөөт хэлэлцээрүүдийг .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Очирбат гишүүн асуулт асууна.

**Г.Очирбат:** Гишүүддээ бол ажлын хэсгийнхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд өнөөдөр бид нар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж байгаа юм.

Тэгэхээр энэ нөгөө асуудлынхаа хүрээнд бас бүгдээрээ ярилцах ёстой байх гэж бодож байна. Өнөөдөр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооныхон маань хуралдаж байна. Одоо тэгээд сүүлийн үед нөгөө микрофон дээр юм ярихаар хэтэрхий чанга дуугараад байна гэсэн шүүмжид өртөөд байгаа. Тэгэхээр парламентын засаглалыг дэмжиж байсан эмэгтэй гишүүдээ өмөөрсөн. Тэгсэн бүүлийдсэн сошиалаар дүүрэн. Дараа нь энэ мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудыг Засгийн газар нь худалдаж авчхаад, гэрээгээр мөнгө өгөөд, өөрийнхөө талд ажиллуулаад байна гэж хэлсэн бас бүүлийдсэн. Өнөөдөр одоо дахиад бүүлийдүүлэхэд бэлэн байна. Өнөөдөр энэ хамт өргөн мэдүүлсэн 2 хуулийн төсөл орж ирж байгаа. Нэг нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль Нөгөөдөх нь НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах орж ирж байгаа юм.

НӨАТ-т өөрчлөлт оруулж ирэхэд та хэд санаж байвал бид нар .... 1 минутаа нэмээд авчихна шүү дарга аа, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөр өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлт оруулахдаа МАН-ын мөрийн хөтөлбөр, АН-ын мөрийн

хөтөлбөр, иргэдийг бас энэ татварын дарамтаас буулгая. Татварын дарамтыг иргэддээ үзүүлэхээ больё гэж НӨАТ-ыг шаталсан маяг руу оруулсан. Ингэхдээ дунд болон бага орлоготой иргэдэд зориулж 0-500 мянган төгрөгийн худалдан авалт хийвэл буцаан олголтыг нь 100 хувь олгоё. 500-1 сая төгрөгийн худалдан авалт хийвэл 50 хувь олгоё. 1 саяас дээшээ бол 20 хувиар нь олгоё гэсэн ийм шаталсан маягийн системийг НӨАТ-ын тухай хуулийн 15.2.1 дээр оруулж ирээд дээр баталсан. Энэ чинь 2025 оны 11 сарын 14-ний өдөр. Өнөөдөр жил ч болоогүй бид нар эндээсээ ухрах гэж байна шүү дээ. Баталсан хуулиасаа. Тэгээд яагаад энэ 2027 оны төсвийн хүрээгээ, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулиа батлагдсан хуулийнхаа хүрээнд оруулж ирж болдоггүй юм. Сангийн сайд байна. Эдийн засгийн хөгжлийн сайд байна. Төсвийн тогтвортой байдлынхан байна. Бүгдээрээ хариулчхаарай. Энэ хуулийг одоо хүчингүй болгох гэж байгаа зорилго, зорилт чинь юу юм. Төсөв чинь тасарчхаад байгаа юм уу. Мөнгөгүй болчихоод байгаа юм уу. Иргэдийнхээ кармааг дандаа ингэж тэмтрэхээ больчихооч. Тийм биз дээ. Тэгэхгүй тэгээд нөгөө хууль нь уг нь 10 сарын 1-ээс хэрэгжих ёстой байсан. Хэрэгжихээс нь өмнө одоо ингээд хүчингүй болгоно гээд оруулаад ирэх юм. Тэгээд энийг бол гайхаж байна. Тэгээд гурвуулаагаас нь ямар зорилготой энийг оруулж ирсэн юм гэж асуучхаад, тэгээд тодруулъя.

**Н.Наранбаатар:** 5 номер.

**Ж.Энхбаяр:** Бид нар нөгөө урсгал зардлаа жоохон тооцоогүй нэмчихсэн. Багш, эмч нарын цалин ирэх онд 2 их наяд нэмэгдэнэ. Энэ хэрвээ энэ хууль одоо яг хүчин төгөлдөр мөрдөөд, 20 хувийн буцаалтыг 50 хувь болгочих юм бол багаар бодоход 1,8 их наядын орлого тасарна гэсэн үг. 1,8 их наядын орлого тасрахад нөгөө талд 2 их наядын багш, эмч нарын цалин, тэтгэвэр нэмэх асуудал байхгүй гэсэн үг. Тэгэхээр энэ бүгдээр яг энэ өнцгөөс нь одоо бүгдээрээ яах вэ. Цалин, тэтгэврээ нэмэх үү, эсвэл НӨАТ-аа буцаан олгох уу гэдэг л шийдэл байхгүй юу. Бидний нөгөө орлогын хэмжээ маань хүрэхээ болиод байна шүү дээ. Хүрэхгүй болчихоод байна. Хөрөнгө оруулалт ирэх 2027 онд шинээр хийх хөрөнгө оруулалт 1 ч төгрөгийн хөрөнгө оруулалт байхгүй. Одоо явж байгаа урсгал зардал 3,6 дутуу байгаагаасаа 2 их наядыг санхүүжүүлж чадвал их юм. Хэрвээ энэ 1,8 их наядын НӨАТ-ын буцаан олголт явчихвал ирэх онд үргэлжилж байгаа хөрөнгө оруулалт ч байхгүй. Зөвхөн бид нар НӨАТ-аа олгоод л, цалингаа тавиад л, халамжаа өгөөд л, тэтгэврээ өгөөд л, хүүхдийн мөнгөө өгөөд л ингээд л болоо. Бодит байдал энэ байгаа байхгүй юу.

Бид нарын нөгөө төсвийн хөгжлийн хөтөлбөр бодлого авч явдаг хөрөнгө оруулалтын орон зай чинь 2,2 их наяд болчихсон. Тэр 2,2 их наядыг авч гарахын тулд энэ НӨАТ-ын буцаан олголтыг хойшлуулъя л гэж байгаа юм. Тодорхой хэмжээнд. Тэгж байж тэр 1,8-ыг эх үүсвэр талдаа авч үлдэж, төсвийнхөө хөрөнгө оруулалтаа авна. Энэ бол цэвэр л улс төрийн шийдэл байхгүй юу. Аль нь бид нарт хэрэгтэй вэ, Монгол Улсад аль нь хэрэгтэй байна. Бид нар бол тооцоог нь гаргаад ийм нөхцөл байдал үүсэж байна шүү. Энэ бол урсгал зардлыг бууруулах бололцоогүй урсгал зардлууд байхгүй юу. Цалин, тэтгэвэр, ингээд урамшуулал нэмчихсэн. Буцаах аргагүй болчихдог. Тэгэхээрээ ингээд нэмэх зардлаа бас их тооцож байхгүй бол яг ийм байдал руу л төсвөө үндсэндээ бид нар авааччихсан гэсэн үг.

**Н.Наранбаатар:** Очирбат гишүүн тодруулна.

**Г.Очирбат:** Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд минь энийг хэлэлцэж болохгүй шүү. Энэ МАН, АН-ын мөрийн хөтөлбөрт байгаа

татварын дарамтаас иргэдээ чөлөөлье гэж бүгд хэлж байсан. Одоо яг энэ хуулийг өнгөрсөн жилийн 11 сарын 14-ний өдөр баталсан. Өнөөдөр бид нар 10 сарын 1-ээс хэрэгжих гэж байхад жил болоогүй байхад хуулийг өөрчлөөд, иргэдийнхээ олж байгаа орлого, кармааг сэгсрэх гэж байгаа хууль. Энийг баталж болохгүй шүү гэдгийг, хэлэлцэж болохгүй шүү гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт хамтарсан Засгийн газрын үед 226 төрийн албан хаагч нар байж байхад матриц шинжилгээ хийгээд чиг үүргийн давхцал нь 10 хувьтай байна гэж гаргаж ирээд ингээд төсөв хэмнэлтээ хий гэдэг санал, санаачилгыг дэвшүүлж байсан. Эрх баригч нар гүйцэтгэх засаглалынхан юу хийсэн гэхээр зүгээр албан бичиг явуулаад, таньдаг хүнээ авч үлдээд, таньдаггүй хүнээ тэр мэргэжилтэн эксперт байна уу хамаагүй хал гэдэг юм явуулаад л бүгдийг нь халсан. Тэгээд ийм байдалтай байж болохгүй. Та хэд өөрсдөө ажлаа сайжруул. Төсвөө хэмнэ. Дотооддоо зохион байгуулалтаа хий.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Энхбаяр сайд 5 номер.

**Ж.Энхбаяр:** Одоо энэ дээр улс төрөөс илүү бид нар яг л бодит эдийн засгийн орлого, зарлагаа л ярьж байна. Орлогын хэмжээ чинь манай нөгөө чадавхдаа баригдаад, дээд потенциалаа бид нар тулчхаад байна шүү дээ. Нүүрс дээд хэмжээндээ хүрсэн. Зэс дээд хэмжээндээ хүрсэн. Төмөр замын тээвэр дээд хэмжээндээ хүрсэн. Эрчим хүч чинь дээд хэмжээндээ цахилгаан, дулаанаа үйлдвэрлэчихсэн. Ажиллах хүчээ бид нар 63 хувиар дайчилчихсан. Одоо манай бий болгосон эдийн засаг маань гол потенциалаа шавхаад байна. Тулгаад байна. Одоо шинэ эдийн засаг. Эдийн засгаа томруулж байж энэ хүсэл, мөрөөдлөө санхүүжүүлэхгүй бол одоо тулчихсан юм маань энэ бүх цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөнөөс илүү гарахаа больчихлоо шүү дээ. Тэгэхээр та одоо 1,8 их наядыг уриалж байна тийм үү. Энийгээ өгөх ёстой гэж. Нөгөө талд 1,8 их наядын хөрөнгө оруулалт зогсоно. Одоо хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд чинь хэрэгжихгүй гэсэн үг. Тэгэнгүүт тэн дээр юу үүсэх вэ та бодож байгаа биз. Одоо хэрэгжээд явж байгаа авто зам, барилга, эмнэлэг, сургууль олон зүйл чинь явахгүй гэсэн үг. Сая гадаад зээлийн ашиглалтаар .../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Яах гэж гүйцэтгэх засаглал байгаа юм. Энэ асуудлуудыг шийдэх гэж байгаа. Өнөөдөр 3,5 сая иргэдэд 20 гаруй сайд, 16 яам байгаа. Энэ бүтцээ багасга л даа тэгвэл. Өөрсдөөсөө эхэл л дээ. Тамгын газруудын зардал 3, 4 дахин өссөн шүү дээ. Би жил болгон төсөв дээр хэлдэг. Хэн ч тоодоггүй. Тэр зардлаа тана л даа. Өнөөдөр зэс, алт, нүүрсний ханш ийм өндөр байж байхад гадаад нөхцөл байдал ийм таатай байж байхад та нар өнөөдөр бид нар ажлаа хийж чадахгүй байна. Энэ татвар төлж байгаа иргэдийнхээ кармааг сэгсэрье. 1,8 их наяд төгрөгийг нь сэгсэрье гэж хэлж байгаагаасаа ичих ёстой гэж харж байгаа юм. Асар олон төрийн албан хаагч нар, Монголын бүх топууд манай энэ яам, Тамгын газар ажиллаж байгаа. Толгойгоо ажиллуул, төсвөө хэмнэ. Ямар боломж бололцоо байна. Тэр болгоноо гаргаж ирээд, оруулж ир. Бид нар тэрийг чинь дэмжээд батлаад өгье. Татвараа бууруул. Иргэдийнхээ ачааг хөнгөл. Иргэд чинь орлоготой, мөнгөтэй байж байж улс эх орон чинь цаашаа явна. Дарга нар мөнгөтэй байлаа гээд улам л уруудаж байгаа биз дээ.

**Н.Наранбаатар:** Асуулт уу, үг хэлсэн үү. 5 номер Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Засгийн газраас өргөн барьж байгаа Татварын багц хууль хувийн хэвшил, аж ахуйгаа дэмжсэн ийм зохицуулалттай. Одоогийн энэ асуудал бол иргэн төвтэй л байгаа юм л даа. Хувийн хэвшлийг дэмжиж байж хувийн хэвшил маань ажлын байр бий болгож, татвар төлж байж эдийн засаг чинь энэ хүндрэлийг давахад л хувийн хэвшлээ дэмжих нь эн тэргүүнд байна гэж үзэж байгаа юм. 1 дүгээр асуудал.

2 дугаарт манай энэ төсвийн зарлага гэж энийг та нэг үз. Үндсэндээ манай төсвийн 80 гаруй хувь нь халамж, цалин, хүүхдийн мөнгө. Буурах бололцоогүй. Цаана үлдэж байгаа 20 хувь дотор чинь гадаад зээл, өр төлбөр, төрийн байгууллагууд чинь урсгал зардлууд орчхож байгаа юм. Тэгэхээр бидэнд байгаа нөөц 2,2 их наяд байна. Хөрөнгө оруулалт. Энэ 2,2-ыг авч үлдэх үү, эсвэл энийгээ НӨАТ-ын буцаалт болох уу гэдгийг л та бүхэн шийдээч ээ л гэж байгаа юм. Энэ Их Хурал өөрөө энд хууль гаргаж нэмсэн зардлууд. Энийгээ заримыг нь буцаах уу л гэж байгаа юм.

**Н.Наранбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Очирбат, Золжаргал гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн үг хэлье.

**Л.Соронзонболд:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-ын тэр 3 сарыг гэдгийг хасах тухай саналыг бол дэмжихгүй байгаа. Энэ чинь төлөвлөгөө батлаад, гуравхан сарын дараа юмаа өөрчилнө гэж. Тэгэхээр яагаад одоо хэлэлцэж байх шатдаа энийг өөрчилж болохгүй гэж. Тэгээд та нар тооцооллоо хийж байх ёстой шүү дээ.

**Н.Наранбаатар:** Пүрэвдаваа гишүүн үг хэлнэ. Энхбаяр сайдыг үг хэлэх жагсаалтад оруулаарай. Жадамбаагийн Энхбаяр сайдыг.

**Д.Пүрэвдаваа:** Бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ дагасан хууль, төсвийн хүрээ, хөгжлийн хөтөлбөр гээд энэ дагасан хуулиуд дээр тусгагдаагүй хэд хэдэн зүйлийг санал болгож хэлэх гэсэн юм. Ялангуяа энэ махны үнийн өсөлт, дээрээс нь шатахууны үнийн өсөлт, үүнтэй уялдуулаад логистикийн өсөлтүүд гарч ирнэ. Хавар болж байгаа. Тариаланчдад бол маш хүнд нөхцөлүүд үүсэж байгаа. Дээрээс нь жижиг, дунд бизнес эрхлэгч нарт энэ татварын дарамт асар өндөр байгаа. Одоо энэ дайнтай холбогдуулаад гэнэтийн үнийн өсөлт дээр уялдсан төлөвлөгөө хэрэгтэй байдаг юм байна. Ялангуяа жишээгээр дурдах юм бол Австрали улс гээд тэгэх юм бол яг энэ үе дээрээ жижиг, дунд бизнесийгээ дээрээс нь улирлын шинжтэй үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдийнхээ татварын хөнгөлөлтүүдийг олон нийтэд ил болгоод, ярилцаж байгаад буулгаад, тэгээд том буюу уул уурхай, Оюутолгойтой, дээрээс нь энэ нүүрстэй холбогддог том том компаниудтайгаа Засгийн газар нь хэлэлцээрт ороод, тэр зөрөөгөө богино хугацааны төлөвлөгөөнд тусгаад ингээд явж байна. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн сайд та энэ дээрээ анхаараад, ялангуяа НДШ, дээрээс нь энэ НӨАТ гэдэг асуудлууд бол бүр энэ дундаж давхарга буюу 200 орчим мянган бүртгэлтэй аж ахуйн нэгжээс чинь бол яг өдөр тутам үйл ажиллагаа явуулж байгаа нь 50 орчим мянга л байгаа шүү дээ. 50 мянган энэ ЖДҮ энэ жижиг болон дунд бизнес эрхлэгчдийнхээ тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс Засгийн газар энэ богино хугацааны энэ ялангуяа гэнэтийн үнийн өсөлттэй холбогдуулсан төлөвлөгөө ард түмэндээ танилцуулмаар байна. Миний санал ийм байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Мандхай гишүүн санал хэлнэ.

**М.Мандхай:** Ерөнхийдөө энэ төсвийн хүрээний мэдэгдэл ер нь бол ингээд бид нар эдийн засгийн өсөлтийн талаар ярихаараа л дайн дажин гээд л хүнд байгаа нөхцөл байдлыг ярьдаг. Тэгсэн мөртөө ингээд төсвийн хүрээгээ оруулж ирэхдээ төсвийн зарлагын хэмжээгээ дандаа өсгөсөн, өсгөж оруулж ирж байгаа буюу эдийн засгийн өсөлтөө хэтэрхий өөдрөг тавьж, төсөв тавиулдгаа бас болимоор байна. Одоо 2025 онд жишээлбэл нийт зарлага 31 их наяд байсан. 2026 онд бол 32 их наяд, 2027 онд ингээд 36 их наяд төгрөг гээд тасралтгүй энэ зарлага өсөж байна. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3 дээр энэ урсгал зардлын хэмжээг тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй гээд тусгай шаардлага тавьчихсан. Тэгээд эндээ нийцүүлэх гээд нөгөө эдийн засгийнхаа өсөлтийг ингээд өөдрөг тавьж орж ирдэг. Тэгээд тэр нь ерөөсөө бодит хөрсөн дээрээ буудаггүй. Тэгэхээр энэ төсвийн хүрээ, төсвийн төлөвлөгөөгөө бид нар яаран батлах нь бас л учир дутагдалтай гэж бодож байна. Тэгээд бүх энд сууж байгаа гишүүд бол өөрсдөө бас яг санал нэг байна. Тэгэхээр энэ дээр бол бид нар нэлээн сайн ярилцах хэрэгтэй байх. Ажлын хэсэг гарч илүү энэ судалгаа тооцоотой нь бид нар бас өшөө нарийн ажиллаж явахгүй бол яг энэ чигээр нь бид нар батлах юм бол хэдүүлээ бас энэ ядуурлын түвшин, амьжиргаа, ард иргэдийн байдал, ажилгүйдлийн түвшин чинь улам их нэмэгдэж гаарахаар ийм эрсдэл харагдаж байна гэж дүгнэж байна.

**Н.Наранбаатар:** Батсуурь гишүүн үг хэлнэ.

**Ж.Батсуурь:** Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг бол 3 орчим хувааж төсөв дээр тавьдаг л даа Энхбаяр сайд аа. Тийм учраас энэ шатахууны зардал инфляцтай холбоотой үнийн өсөлттэй холбоотой Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хамтарсан ажлын хэсэг гарвал яасан юм бэ. Жишээлэх юм бол 2026 оны төсөвт сууж байгаа хөрөнгө оруулалт бол 2024, 2025 оны төсөв магадлалтай байгаа. 2025 он, 2024 оноос шилжиж ирж байгаа хөрөнгө оруулалт бол бүр 2021, 2022 оны төсвийн магадлалтай байгаа. Тэгэхлээр ер нь ковидын он жилүүдэд бол барилгын салбарын ажилчдын ажлын тариф үнийн өсөлттэй холбоотой барилгын салбарынхаа хувийн хэвшлийн компаниудыг үндсэндээ татаад унагачихсан. Одоо энэ замтай холбоотой хөрөнгө оруулалт улсын төсөв дээр тавигдсан. Үүний үнийн өсөлтийн асуудлуудыг, инфляцын асуудлуудыг эртхэн цэгцэлж, 2027 оны төсөв дээр зөрүүг нь оруулж ирэхгүй бол Монгол Улсын байж байгаа замын чиглэлийн газар шороо, түүнтэй холбоотой хөрөнгө оруулалт авсан компаниуд үндсэндээ хөл дээрээ унах нь. Жишээлэх юм бол 2024 оны төсвөөр дизелийн түлшний үнэ 3 мянга хүрэхгүй байсан бол өнөөдөр бараг 40-өөд хувь өсчихсөн, 40 гаруй хувь өсчихсөн. Тэгээд дээр нь 3, 4 жилийн инфляцыг нэмэх юм бол энэ ингээд 50, 60 хувь өсчихсөн. Гэтэл нийт ажлынх нь 60, 70 хувь нь газар шорооны ажил байдаг. Тэр ажлынх нь 60, 70 хувь нь шатахуун бусад материалтай шууд холбоотой энэ ажлуудыг бол онцгой анхаарахгүй бол болохгүй нь. Би уг нь Мэндсайхан сайд та 2-ыг хамт байж байгаад тэгвэл би асуулт асуугаад та нарын ийм тийм гэх нь бол илүүц байна. Баахан давагдашгүй хүчин зүйлүүдийг сонсож байна. Ойлгож байна. Тэгэхээр асуудлыг бол бие биеэ шүүмжлэх ч гэдэг юм уу, улс төрийн өнгө аяс ч гэдэг юм уу тэр агуулгаар нь биш, 2027 оны төсөв бол шинэ зүйл гэхээсээ илүү хуучин 2024, 2025, 2026 онд тавигдсан төсвийн хөрөнгө оруулалтаа аварч үлдэх, тэнд шалгарсан компаниудаа эдийн засгийн хямралд оруулчихгүй байх энэ тал дээр нь онцгой анхаарч ажилламаар байна Энхбаяр сайд аа. Та одоо Засгийн газрын Тэргүүн Шадар сайдын хувьд Ерөнхий сайдыг орлоод сууж байна. Дээр нь төсөв, мөнгөний бодлогыг барьж байна. Мэндсайхан сайд алга байна. Тэгэхдээ манай Сангийн яамныхан байж байна. Төсвийн бодлого, хөрөнгө оруулалт бол үндсэндээ 2027, 2028 оны төсөв шинийг бол шинэ магадлалаар орно. 2024, 2025, 2026 оныхоо хөрөнгө оруулалтад суусан төсвийг л энэ инфляцын болон шатахууны хямралыг нь

2027 он дээр тусгаж л аврахгүй бол өнөөдөр ЖДҮ-лэл, гурилынхыг унагачхаж байна. Барилгын салбарыг унагачхаж байна. Өндөг гээд бас янз бүрийн л байдлуудаар татаж унагаад л байна л даа. Энэ зам, тээврийн салбараа ийм төсвийн бодлогоор дэмжиж, инфляц, шатахууны зардлынх нь зөрүүг 2027 оны төсөвт суулгахгүйгээр Монгол Улс чинь ер нь гүн хямралд орох нь байна шүү. Бүтэн үлдэх салбар гэж байхгүй болох нь байна шүү. Энэ дээр одоо дөнгөж 5 сард талдаа орох гэж байна. Төсвийн хүрээний мэдэгдэл, тэгээд төсөв 9 сарын 1 хүртэл өргөн барихад 2 яам 2027 оны төсөв дээр энэ төсвийн зөрүүг заавал бодож, итгэлцүүрээр юм уу, инфляцаар нь байдаг юм уу, үнийн өсөлтөөр нь байдаг юм уу төсвийн нэмэгдлийг хийхгүйгээр бол болохгүй гэсэн ийм саналыг хэлж байна. Би та бүхэнд бол янз бүрийн байдлаар хатуу хөтүү үг хэлж, янз бүрийн байдлаар асуулт асуухгүй байна шүү Энхбаяр сайд аа. Энэ бол би бүр онцгойлон хэлж байна. Өмнө нь одоо барилгын салбарын асуудлыг ... 1 минутаа авчхаж болох уу.

**Н.Наранбаатар:** Тийм дэг байхгүй. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Батсуурь гишүүн яг хашир, орон нутагт яг төсөв барьж байсан хүний хувьд, сайд байсан хүний хувьд маш сайн мэдэрч яриад байна л даа. Нөхцөл байдал амаргүй болсон. Инфляц, үнийн өсөлт Засаг яаралтай хариу арга хэмжээг авах ёстой. Эдийн засгийн хохирол багатай авч гарах хэрэгтэй байна. Энд засаг хурдан маневртай хариу арга хэмжээ авах боломжоо авахын тулд энэ дагасан хуулиуд оруулж ирж байгаа байхгүй юу. Энэ тодотгол хийх үед энэ үйлчилдэггүй болгоод өгөөч. Төсвийн үед 3 сар нь явдаг юм байгаа биз. Асуудал тулчхаад байхад бид нар тодотгохгүй гээд, намар болох гээд байна шүү дээ. Наана нь тодотгож, Засгийн эрхийг нь өгчхөөд, Засгийн ажил хийгээд шахмаар байна. Сая Батсуурь гишүүний хэлдэг энэ хөрөнгө оруулалтын чинь өртөг зардал чинь өөрчлөгдчихсөн. Өсчихсөн хөрөнгө оруулалт инфляц орчихсон өндөр өсөлт дээр шинээр төсөв хөтөлбөр зарцуулаад ямар үр ашиг байгаа юм. Энэ чинь түр зуурын богино хугацааны энэ 2026 ондоо үргэлжлэх дэлхий нийтийг хамарсан хямрал яваад байна шүү дээ. 2027 оноос тогтворжчих болов уу. Тэгэхээр энэ дээр бид нар бодлого нь тэр байхгүй юу. Хуучингаа үргэлжлүүлээд, тохиргоогоо хийгээд, энийгээ үр дүнтэй дуусгая. Шинээр юм хийгээд баахан өндөр өртөгтэй төсөл хөтөлбөр санхүүжүүлээд яах вэ. Мөнгөний нийлүүлэлтээ аж ахуйн нэгж лүүгээ хийе. Иргэд биш шүү, иргэдээсээ биш аж ахуйн нэгж лүүгээ хийж, аж ахуйн нэгжээ дэмжиж байж энэ эдийн засгийн өсөлт ажлын байр, энэ татвар хураамж чинь гарч ирэх гээд байна. Тэрнээс урсгал зардал маань цалин, тэтгэвэр лүүгээ, иргэд лүүгээ ингээд буцаад НӨАТ-аараа дамжин олгочихоор эдийн засгаа хөдөлгөх юм нь их сул болчихоод байна шүү дээ. Бидэнд байгаа бололцоо чинь маш хязгаарлагдмал. Маш их хэмжээний урсгал зардлыг тооцоогүйгээр эрс нэмчихсэн. Уучлаарай. Их Хурал нэмсэн. Хэд хэдэн огцом хэмнэлт хийчихлээ шүү дээ. 2027 онд 4-6 их наядын нэмэлт зардал үүсэх гээд байна. Урсгал зардал дээр. Хаанаас олж өгөх юм бэ. Боломжгүй байна шүү дээ. Тэгэхээр хариу арга хэмжээ авах, хөрөнгө оруулалтаа тогтвортой хангаж үлдэх ийм зайлшгүй шаардлага үүсчхээд энд төсвийн тодотгол хурдан хийнэ. Батлагдаад л, төсвийн тодотголоо өргөн бариад, 6 сар сардаа багтаж тодотголоо хийж аваад, цэгцлээд цаашдаа явмаар байна шүү дээ. Тэгээд та нар эргээд засгийг ажлаа хий гэж шахмаар байгаа байхгүй юу. Одоо эсрэгээр нь харин та нар битгий ажил хий, намар хүртэл орхи. Гадаад зээлийн ашиглалт хэрэггүй. Гадаад зээлийн ашиглалтыг чинь дэмжихгүй. Засаг бүх л эдийн засгийн бодлогоо оруулж ирлээ шүү дээ. Гадаад зээл ашиглалт нэмэгдүүлье. Тодотгол хийе. Хөрөнгө оруулалтаа ингэе гэдэг. Тэгэхээр энэ асуудлыг та нар ойлгоод өгөөч. Намар оройтно бүгдээрээ. 9 сард энэ хуулиар бол бид нар 6 сарын 1-нд батлагдана. 9 сарын 1-нд өргөн барих эрх үүснэ. 10 сард хэлэлцэгдэхэд оны төгсгөлд шахчихсан баахан дутуу гүйцэтгэлүүд, баахан

мөнгөө авч чадаагүй аж ахуйн нэгжүүд, цалин, тэтгэвэр чинь тасраад эхэлнэ. Энэ чинь бодит байдлыг хараад, эрсдэлийг тооцоод ингээд оруулж ирж байгаа зүйл шүү дээ. Ингээд хамтраад урагшлуулмаар байгаа байхгүй юу даа. Таны ярьж байгаа ажлын хэсэг үү. Энэ бол зайлшгүй ажил байхгүй юу. Зайлшгүй тохиргоо хийж байж явахгүй бол 2021, 2022 оны зардал дээр одоо 2024 оны инфляц өгчихсөн юун дээр баахан хөрөнгө оруулалтын ажил, тендер явчихсан аж ахуйн нэгжүүд чинь ажил нь явахаа больчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр дагасан энэ 2 хуулийг дэмжээд өгөөч ээ л гэж. Оройтно гэж. Тэгээд эцэст нь хэлэхэд МАН-ын бүлгийн гишүүд бүлгийн шийдвэр гарсан шүү. Дэмжлэгээ үзүүлээд, бодлогоо дэмжээд яваарай гэж хэлэхийг хүсэж байна.

**Н.Наранбаатар:** Гишүүнийхээ хувьд сая үг хэлсэн. Одоо Очирбат гишүүн үг хэлнэ.

**Г.Очирбат:** Одоо ямар Энхбаяр сайдад хичээл заалтай нь биш дээ. Би одоо уг нь суралцах ёстой хүн гэж хардаг. Энэ ахмад парламентчдаасаа. Үгүй ээ, та попорсон юм ерөөсөө байхгүй. Попорсон юм ерөөсөө байхгүй. Танд зөндөө боломж байгаа шүү дээ. Бид нар боломжоо олгоё. Чөлөөлье гээд явж байна. Зөвшөөрлийн тухай хууль дээрээ ажиллачихсан. Хөрөнгө оруулалтынхаа тухай хууль дээр ажилла, гадна, дотнынхонд нээлттэй болго, дотоодынхны зах зээлийг нь тавьж нээж өг, Биржийн тухай хуулиа оруулж ир. Баахан тэр баяжуулах үйлдвэрүүд чинь хэдэн зуугаараа зогсчихсон байна гээд та ярьж байсан биз дээ өөрөө. Энэ Аж үйлдвэрийн сайд нь хүртэл яриад байсан. Ингээд боломжийг нь нээж өгөх ажлууд руугаа ор л доо. Төрөө цомхон байлгая. Чиг үүрэг, ажил албан тушаалын матриц шинжилгээ хийгээд үзье гэсэн. Үгүй шууд албан бичиг явуулаад л таньдгаа авч үлдээд, танихгүйгээ хал гэсэн л юмаар явчихсан байна лээ шүү дээ тэр 9 хувь чинь. Ингээд дотооддоо танай кабинет хамтын шийдвэр гаргаад мөнгөгүйгээр хийж болох юмнуудаа оруулж ир ээ.

Татвар төлөгч буюу одоо иргэдэд ганц боломж олгосон энэ хуулийн төслийг битгий хөндөөч ээ. 0-500 мянган төгрөгөөр худалдан авалт хийхэд НӨАТ-ыг нь 100 хувь буцаагаад өгчихдөг, 500-1 сая төгрөгийн худалдан авалт хийхээр НӨАТ-ыг нь 50 хувь буцаагаад өгчихдөг, 1 саяас дээшээ бол хуучин 20 хувиар нь байдаг ийм шаталсан систем оруулаад ирсэн юм уг нь. Энэ чинь танай намын мөрийн хөтөлбөрт ч байгаа, манай намын мөрийн хөтөлбөрт ч байгаа. Үгүй ээ, тэгээд энийгээ л хэдүүлээ хийе. Ард түмэндээ амласан юм бол амлалтдаа хүрцгээе. Одоо худлаа бие биедээ гоё юм ярьж, гоё гоё асуулт асуудаг юм байхгүй. Батлагдсан хуулийнхаа хүрээнд төсвөө, төлөвлөгөөгөө оруулаад ирчих. Тэгээд зовлон жаргал байвал дотооддоо та хэд засаг ярь. Тэгээд иргэд хүртэл шүүмжлээд байна шүү дээ. Энэ танай намын гишүүд хүртэл хэлээд байгаа биз дээ. 20 гаруй сайд, 16 ямаар 3,5 сая хүнд яах гээд байгаа юм бэ. Үгүй ээ, тэрийгээ бод л доо. Энийгээ багасга. Юмаа цахим болго.

Өчигдөр би Боловсролын сайдад бас хэлсэн. Манай бүлгийн хурал дээр орж ирэхдээ баахан материал тараачихсан байсан. Тэгээд наадхаа цахим болгоод явуул л даа. Мөнгөө хэмнэе л дээ. Иргэд чинь тэнчээ мах авах гээд мөнгөө хэмнэж байхад бид энд мөнгөө хэмнэж болно биз дээ Энхбаяр сайд аа. Та одоо олон сонгогдсон төрийн түшээ хүн. Үгүй ээ, хэлж өгөөд байна шүү дээ би танд. Хэлээд байхад та хэд кабинет дээрээ ярьж байгаад оруулаад ир л дээ. Кабинетаа ингэж багасгая, төсвөө ингэж багасгая, чиг үүргийн давхцал ийм болчихсон байна. Дахиад ингээд ажиллая. Гадаад, дотоодынхоо хөрөнгө оруулалтыг татъя. Биржийн тухай хуулиа өөрчилъе. Одоо байгаа гацсан төсөл хөтөлбөрүүдээ явуулъя. Судсыг нь

тэлье. Бизнесийнхээ энэ судсыг тэлж өгч байж л эдийн засаг чинь томорно шүү дээ. Эдийн засаг чинь томорч байж татвар төлөгч чинь нэмэгдэнэ. Үгүй ээ, тэгээд аягүй энгийн л ойлголт шүү дээ. Бүгд мэдэж байдаг. Тэгээд цагаа тулахаар зөвхөн иргэдийнхээ кармааг ухъя л гэдэг шийдэл рүү орж байна гэдэг бол байж болохгүй гэж би зүгээр хувь гишүүний хувьд харж байна. Тэгээд энэ Төсвийн. Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ уриалахад энэ хуулийг хэлэлцэж болохгүй. Ард иргэд харж байгаа шүү. Дунд болон дунджаас доошоо орлоготой иргэдийг дэмжих гэж, мөнгөтэй байлгах гэж, орлоготой байлгах гэж энэ хуулийн төсөл батлагдсан. Одоо жил болоогүй 10 сарын 1-нд хэрэгжиж эхлэх гэж байхад нь наана нь ингэж гацааж, түгжиж, хаяж байна гэдэг бол үнэхээр байж болшгүй зүйл гэж бодож байна. Тэгээд Засгийн газрынхан ажлаа сайн хийх хэрэгтэй. Илүү нухацтай ажилла. Төсвийн тогтвортой байдлынхны өгч байгаа зөвлөгөөг сайн ав. Хийхгүй. Жил болгон л зөвлөгөө өгөөд л байдаг, зөвлөгөө өгөөд л байдаг. Нэмэгдсэн юм байхгүй, сайжирсан юм байхгүй л ажиллаж байгаа шүү дээ. Тэгэхээр та хэд кабинетаараа хамтын шийдвэр гаргаад, энэ иргэд дээр татварын дарамтыг нь бага ч гэсэн чөлөөлж, бага ч гэсэн дарамтаас ингэж багасгаж өгч байгаа юмыг битгий хөндөөч. Энэ хуулийнхаа төслөө битгий өөрчлөөч. Үүнийхээ хүрээнд 2027 оны энэ төсвийн хүрээ болон 2028-2029 оны төсвийн төсөөллийнхөө тухай хуулийг өөрчлөөд оруулж ирээч гэсэн саналтай байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Гантөмөр гишүүнийг жагсаалтад оруулаарай. Одоо Ганбаатар гишүүн үг хэлнэ.

**Г.Ганбаатар:** Энхбаяр сайд аа, сая та гадаад зээлийн ашиглалттай холбоотой ярьж байх юм. Гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах хууль хэнээс болж унасан бэ яг үнэндээ. Хэдүүлээ уг нь бол нефтийнхээ үйлдвэрийг, Эрдэнэбүрэнгийнхээ УЦС-ыг явуулчихъя гэсэн нөгөө гуя дагаж хүзүү гэдэг шиг Сэлбийн 500 сая долларыг дагуулаад л ороод ирсэн шүү дээ. Тэрнээс чинь болж унасан шүү дээ. Тэгээд яаралтай Засгийн газраасаа ахиад өргөн бариад, тэгээд зөвхөн тэр хоёрыгоо оруулаад ир л дээ. Дэмжье л гээд байгаа шүү дээ. Тэгээд одоо болохоор иймэрхүү юм яриад хэдүүлээ дэмий шүү дээ. Та хэд ер нь энэ төсвийн хүрээгээ би уг нь энэ жил бас та нараас яг ний нуугүй хэлэхэд арай дорвитойхон реформ хийчихсэн төсвийн хүрээний мэдэгдэл орж ирэх болов уу гэсэн яг л хэвээрээ. Хэдүүлээ хэзээ дорвитойхон шинэчлэл хийх юм бэ. Үндсэндээ урсгал зардлаас өөр хөрөнгө оруулалт гэх юм байхгүй боллоо.

Нэг статистикийн үзүүлэлт. Зээлтэй өрхийн эзлэх хувийн сүүлийн 2 жил тасралтгүй өсөөд, өнгөрсөн оны эцэс гэхэд нийт өрхийн 70,8 хувьд хүрсэн. Өрхийн санхүү, зээлээс хамааралтай болоод сүүлийн 1 жилд өрхийн орлого 14,1 хувиар өссөн ч зээлийн эргэн төлөлт нь 26,9 хувиар өссөн. Өөрөөр хэлбэл энэ юу харуулж байна гэхээр орлогоосоо давсан зарлага асар хурдтай өсөж байгааг товчхондоо хөдөлмөрлөөд байхад улам ядуураад байгааг, дээрээс нь зарлагынхаа зөрүүг зээл авч амьдардаг улс ийм л болсныг харуулж байгаа. Үүний эсрэг бид нар юу хийх юм. Энэ данхар төрөө л багасгах ёстой шүү дээ. Энэ их зарлага гаргаад байгаа нийт төсвийнхөө 75-80 хувийг эзлээд байгаа энэ зарлагаа яаж багасгах вэ л гэдэг асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр уг нь дорвитойхон өөрчлөлт ороод ирэх болов уу гэж бодсон. Ний нуугүй хэлэхэд байна шүү дээ. Энэ та нарын яриад байгаа НӨАТ-ын хууль чинь уг нь 1 сарын 1-ээс хэдүүлээ хэрэгжүүлнэ гээд багш, эмч нарын цалинг нэмэхтэй холбоотойгоор 10 сарын 1 болгосон. Одоо бүр байхгүй болгох нь л дээ. Энэ бас хэний алдаа вэ. Яг үнэндээ Боловсролын яамны дадлага хийсэн сайд, төрийн нарийн, 3 талт үйлдвэрчний эвлэл 3 талтайгаа хэлэлцээрээ буруу хийгээд, гэрээгээ сайн хянаагүйгээс багш, ажилчдын гэдэг үг орж ирснээс болж бид

нарын Улсын Их Хурлаар тавьсан 618 тэрбум төгрөг салхинд хийсэн шүү дээ. Бид нар тийм юм яриагүй шүү дээ. Бид нар тийм юм баталж өгөөгүй шүү дээ. Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурал. Одоо дахиад 1,3 их наяд зөрүүг нь нэмэхийн тулд дахиад 600, 700 тэрбум. Хэний алдаа юм. Хэний алдааг одоо бид нар энд яриад сууж байгаа юм. Тэгээд энийгээ хэд хэдүүлээ зөв ярих хэрэгтэй шүү дээ. Харин тийм. Тэгж гаргасан учраас л энэ чинь ийм болчихоод байгаа шүү дээ. Хэдүүлээ бодитой юмаа бодитойгоор нь яриад, хэнтэй нь хариуцлага тооцох юм, хариуцлагаа яриад. Тэрнээс биш иргэдийн тэр НӨАТ, буцаан олголт, дөнгөж жилийн өмнө баталсан хууль руугаа ороод яах юм бэ. Өөр боломжоо эрэлхийлэх хэрэгтэй. Өөр бусад эх үүсвэрээ сайн нягтлах хэрэгтэй шүү дээ. Үгүй ээ, боломж байгаа. Үүнийгээ бод л доо.

**Н.Наранбаатар:** Жаргалсайхан гишүүнийг нэмээрэй. Одоо Золжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Золжаргал:** Түрүүчийн хэлдэг үгтэй бас санаа нэг байна л даа. Зарчмын өөрчлөлт бол байхгүй. Реформын шинжтэй зүйл бол алга. Ерөнхийдөө яаж эвтэйхэн энэ эдийн засгаа авч үлдэх вэ, яаж эвтэйхэн авч гарах вэ гэдэг хандлагатай төсөл байгаа. 2022, 2023 онд улсын төсөв бүр их аймар огцом өссөн. 2024 онд дагаад өссөн. 2025 онд хүчээр барьсан. Алдагдалгүй төсөв энэ тэр гээд. 2026 онд бас нэлээн чамбай багасгаж байгаад, аргагүй байдлаар батлаад явсан. 2027 онд болохоор яаж эвтэйхэн явах вэ гэдэг иймэрхүү дараалалтай орж ирж байна. Өөрөөр хэлбэл энэ дотор суурь өөрчлөлт байхгүй байна. МАН сонгуулиар 25 хувьд ДНБ-ий 25 хувьд улсын төсвийг барина гэсэн агуулгатай амлалт өгсөн. АН ч тэр, ХҮН нам ч тэр бүгдээрээ эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулна, улсын төсвийн эзлэх хувь хэмжээг багасгана, татварын ачааллыг бууруулна гэж амлалт өгсөн. Энэ юу гэсэн үг вэ гэвэл эдийн засгийг нөгөө намын дарга, танай намын дарга яриад байгаа чөлөөлье гэдэг агуулгаар эдийн засгийн өсөлтийг бизнес рүү аваачъя гэсэн санаа. Төрийг цомхон бөгөөд хүчтэй аж ахуй мөнгөнд орооцолдоод дорой царайлаад байдаггүй болгоё гэсэн санаа.

Тэгэхээр төрийг цомхон болгоё гэхээр нөгөө төрийн албан хаагч чинь 1/3 нь зохион байгуулалтаар өөрчилж болох, нөгөө баахан олон хэсгийн ахлагч нарын цалин хөлс, зардал. Тэгээд эдийн засгийг бизнес рүү нь эдийн засгийн хөдөлгөх хүчин төсөв биш, төсөв байна. Мэдээж идэвхжүүлдэг, түлхдэг, тэр нь угаасаа аль ч улсад байдаг бодлого. Гэхдээ үндсэн хүч нь бол бизнес байг, хөрөнгө оруулалт байг. Хөрөнгө оруулалтыг татах орчин байхгүй болчихлоо. Геополитик яриад байдаг. Үгүй шүү дээ. Өөрсдөө хөөгөөд явуулчихсан. Эрх зүйн орчин нь хүртэл тийм. Битгий Монголд ирж том хөрөнгө оруул гэдэг эрх зүйн орчин өөрсдөө зохиочоод, энэ агуулгуудыг өөрчилсөн байдлаар хөгжлийн төлөвлөгөөгөө ч тэр, төсвийн хүрээний мэдэгдлээ ч тэр хийж оруулж ирэхгүй бол үндсэндээ ингээд дараа жил дахиад одоо маш хэцүү байна шүү дээ гээд л энэ бүрэн эрхийн хугацаа дуусах юм байна. Тийм учраас би дэмжихгүй.

**Н.Наранбаатар:** Жаргалсайхан гишүүн. Жаргалсайхан гишүүний микрофоныг өгөөрэй.

**Д.Жаргалсайхан:** Хэдүүлээ энэ урсгал зардлыг бол нэмэхгүй байх нь их зөв байна. Өмнөх оны тэр ажлын хэсэг дээр бол орж ажилласан. Сая Энхбаяр сайд ажилчид гэдэг үг ярьж байна л даа. Ажилчид гэдэг үг бол ороогүй. Багш нарын цалинг нэмэгдүүлнэ л гэж орсон шүү. Тэгэхээр энийг бол хууль зөрчсөн асуудал болсон. Тийм учраас энэ урсгал зардлыг бол нэмэгдүүлэхгүй байх шаардлагатай.

75-80 гаруй хувь болж байна шүү дээ. Хэдүүлээ ингээд жил ирэх тусам урсгал зардлаа нэмээд байх юм бол энэ улс орон бол төсвөө даахгүй.

Дараагийн асуудал энэ импортын бараа бүтээгдэхүүнийг бид нар эргэж хармаар байна. Харж байхад голлох том дүнгүүдийг бол түлш, шатахуун, эрчим хүч, төмөр хийцэл гээд эзлээд байгаа юм. Тэгэхээр бид нар эндээс юу харж болох вэ гэхээр томоохон төслүүдээ дуусгах шаардлагатай байна л даа. Тэр тусмаа Эрдэнэбүрэнгийн УЦС, газрын тос боловсруулах үйлдвэрүүдийг дуусгах хэрэгтэй. Ингэж байж бидний хувьд энэ импортыг орлох бүтээгдэхүүнээ бол бид нар өөрсдөө 50 хувийг нь ч гэсэн хангах шаардлагатай байна. Үнийн өсөлт бол бас энэ дээр яваад байна.

Дараагийн асуудал тэр мах гээд ярьж байна л даа. Мах тал дээр яривал яг үндэсний үйлдвэрлэл бол яг мал аж ахуй шүү. Монгол Улсын. 250 мянга орчим айл өрх мал буюу малчин өрх байна. Тэгэхээр өнөөдөр махны үнэ өссөнөөр ингээд л Монгол Улсын ард түмний амьдрал дордсон гэж би бол хэлж чадахгүй. Яг хөдөөд яваад очихоор хөдөөгийн ард түмэн юу ярьж байна гэхээр малчид маань малчингүй боллоо. Хөдөө эзэнгүй боллоо, хүнгүй боллоо, залуучуудгүй боллоо. Мал аж ахуйн салбар уналаа гэж ярьж байна. Үнэхээр энэ чөлөөт өрсөлдөөн энэ зах зээл яг зарчмаараа явдаг бол үнэхээр тэнд малын мах үнэтэй болоод, хөдөө аж ахуйн нь сайжирч байгаа бол залуучууд тийшээ очих ёстой. Энэ харин хууль ёсныхоо дагуу зах зээлийнхээ зарчмаар явж байгаа гэж бодож байгаа. Тэгэхээр энэ хиймлээр барих буюу хиймлээр зохион байгуулалттай махны үнийг бууруулах дээр бол би эсрэг саналтай байгаа.

Энэ том төслүүдийг оруулж ирэх дээр ямар санал, санаачилга явах вэ. Сая бол ийм саналууд хэлж байна л даа. Төсвийн тодотгол хийнэ. Энэ том төслүүдээ зогсооно гэж байна. Энэ юу гэсэн үг вэ. Инфляц ийм өндөр байхад дараа жил дахиад үнэ нэмэгдэнэ шүү дээ. Өнөөдөр бид нар энэ том төслүүдийг 2,2 их наядаар барина гээд сууж байгаа бол дараа жил дахиад энэ төсөл хойшлогдох тусам л 2,8, 3 их наяд гараад л явна. Энэ хариуцлагыг хэн хүлээх юм. Ийм мөнгө хэнд байгаа юм. Ирээдүйд алдагдаж байгаа боломжийг бид нар бас тооцох ёстой. Тэгэхээр энэ том төслүүдийг бол ерөөсөө зогсоож болохгүй. Харин ийм үнэ хямд, ийм цаг хугацаатай өрсөлдөж байгаа энэ компаниудыг дэмжих хэрэгтэй байна. Шаардлагатай байна. Тэгэхээр энэ тал дээр миний хувьд бол эсрэг байр суурьтай байгаа шүү. Тийм учраас энэ том төслүүдийг бол яаралтай оруулж ирэх хэрэгтэй. Сая бол тэр Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэрийн төслүүд унаж байна лээ. Энийг бол дахиж оруулж ирэх хэрэгтэй шүү дээ Засгийн газар. Ингэж байж бид нар импортын барааг орлох бүтээгдэхүүн импортоор алдаж байгаа тэр валютаа бол бид нар Монголдоо авч үлдэх шаардлагатай байна. Ингэж байж бид нар инфляцыг зогсооно. Тэрнээс бид нар энэ хөрөнгө оруулалтынхаа зардлыг танаад, урсгал зардлаа нэмэх юм бол харин жинхэнэ бид нар хүнд байдал руугаа явна. Ийм саналыг хэлэх гэсэн юм.

**Н.Наранбаатар:** Гантөмөр гишүүн үг хэлнэ.

**Л.Гантөмөр:** Баярлалаа. Би үг хэлж байгаа шалтгаан бол Их Хурал дээр энэ төрийн сайд нар худлаа ярихаа үнэхээр болимоор байна Энхбаяр аа. Үнэндээ 1 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийг тэлэх тухай 1 ажил хийсэнгүй шүү дээ Засгийн газар. Чи бол Засгийн газартаа илүү шүүмжлэлтэй хандах хэрэгтэй шүү дээ. Юу ч хийхгүй. Мега төслүүдийг мега хулгай болгосон. Хийхгүй гэдгээ зарласан. Гаднын хөрөнгө оруулалтын хуулийг хийхгүй, гаднын хөрөнгө оруулалтыг татахгүй,

Оюутолгойтой хэлэлцээр хийхгүй, Оюутолгойн зээлийн хүүг бууруулахгүй, говийг усжуулах ажил байхгүй, кокс химийн үйлдвэр байхгүй. Үгүй ээ, тэгээд юу ч хийхгүй байж байж Их Хурал руугаа та нар ингээд загнаад, Их Хурал урсгал зардал нэмээгүй. Нэмээгүй. Хамгийн сүүлд тэр нийгмийн хамгааллын хууль батлагдсаныг эс тооцвол би яг 2 жил парламентыг чинь харж байна. Урсгал зардлыг харин энэ Их Хурал бууруулахын төлөө байгаа.

Дэлгэрсайхан одоо тэр Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулъя энэ тэр гэдгийг одоо болиул л даа. Болохгүй шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын хууль чинь эрдэс баялаг дээр явж байгаа эдийн засгийг хязгаарлах ганц бичиг баримт чинь юм байна лээ шүү дээ. Тийм учраас та хэдийг бас ингээд томилоод, шийдэмгий байгаад, энэ эрдэс баялгийн эдийн засаг гэдэг чинь өөрөө их сул дорой эдийн засаг байхгүй юу даа.

Тийм л учраас тийм хууль батлагдаж байгаа шүү дээ. Тэгэхээр би зүгээр энэ ирж байгаа инфляцын хариу үйлдэл бол НӨАТ-ын буцаан олголт. Гарцаа байхгүй. Өөрөөр бид нар ард түмнээ мөнгөжүүлэх боломжгүй. Татварын хуулиа хэдүүлээ шинэчлээд, НӨАТ-ынхаа хувь хэмжээг бууруулах хэрэгтэй. Татварын дарамтуудаа бууруулах хэрэгтэй. Өөр хувийн хэвшлийн дэмжлэг гэж байхгүй. Одоо худлаа ярихаа болих хэрэгтэй. Хувийн хэвшлийг дэмжих ганцхан арга байгаа шүү дээ. Тэр татвар хураамж юмыг нь бууруулж өгвөл дэмжлэг болно. Тэгэхээр одоо Засгийн газар дорвитой бодлогоо зарла. Мега төсөл хийхгүй гэсэн. Тэгвэл одоо юу хийх юм. Тэрийгээ ний нуугүй хэл л дээ. Яагаад хэлэхгүй байгаа юм. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль гэдэг юмыг ер нь янзлах бодлого байна уу. Хөрөнгө оруулалт татах юм уу. Тэрийгээ хэл л дээ. Оюутолгойн тэр зээлийн хүү гэгчийг бууруулах юм уу. Рио Тинто-той хэлэлцээрт орох юм уу, орохгүй юм уу. Рио Тинто гэдэг мангас гараад ирчихсэн. Гадаад өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх хандлага бариад байдаг ийм зүйл байхгүй юу. Энэ бондуудыг хямдруулах, гадаад эх үүсвэр татах дээр ажиллах юм уу, ажиллахгүй юм уу. Ерөөсөө ирээдүйд ирэх төсвийн хамгийн том дарамт чинь энэ бонд байгаад байна шүү дээ. Гадаад бонд байгаад байна шүү дээ. Тэгээд сүүлийн 3, 4 жил гадаад бондыг хязгаарлаад явъя гэдэг ийм бодлого явж байгаа. Нөгөө талдаа энэ бондыг солих арга ухаанаа олохгүй юм уу. Тэгээд Сангийн сайд нь хөнгөлөлттэй зээл байхгүй болж байгаа гээд яриад байгаа.

Тэр нефтийн үйлдвэр гэдэг зүйлийг чинь Их Хурлын гишүүд оруулж ирсэн шүү. Засгийн газар оруулж ирсэн юм шиг худлаа ярихаа болиорой. Өргөн барьсан гишүүн нь Алтаншагай гишүүн шүү. Тэгээд гадаад зээллэгийг ашиглалтыг сайжруулах гээд худлаа нэртэй хууль шүү дээ. Нэр нь худлаа. Хамгийн гол нь тэр газрын тосны үйлдвэрийн чинь мафан юм байна гэж энэ Их Хурал үзээд байгаа шүү дээ.

**Н.Наранбаатар:** Сэддорж гишүүн үг хэлнэ.

**Р.Сэддорж:** Өдрийн мэнд хүргэе. Монгол Улс одоо төсвийн хүрээний хүрээгээ ярьж байгаа. Эндээсээ илүү хальж ярихгүй гэдэг зүйлээ ярьж байгаа. Өнгөрсөн ноднин ч байна уу, уржнан ч байна уу бас гэнэт гэнэт юмнууд орж ирдэг. Тэгэхээр энэ хүрээнээс давсан, хальсан юмнууд бол хөөцөлдөх шаардлагагүй. Тэрийг бол Улсын Их Хурлын гишүүд санал хураалтаар бас шийдэж байсан. Бид бол энэ том төслүүд юм уу, томоохон асуудлууд руу их анхаарал хандуулж байна. Яг цаана чинь бол хүүхэд үдийн цайгаа уухгүй байгаа шүү дээ. Тэгээд дэлхийн 180 гаруй орноос 90 улс нь үдийн цайгаа өгдөг юм байна. 90 улс нь бол үдийн цай өгдөггүй орон юм байна. Манайх бол хагас дутуу өгдөг юм байна. 1-5 дугаар ангид үдийн цайгаа өгдөг юм байна. 6-12 дугаар ангид өгдөггүй. 6 дугаар ангийн хүүхэдтэй уулзсан байна шүү

дээ. Тэгээд би бас үдийн цай уудаг ангидаа байхад гоё байжээ, одоо бас анги дэвшсэн чинь цай, хоол юу байхгүй, жоохон онцгүй боллоо гэж ярьж байна. Тэгэхээр Монгол Улс бол энэ бол төсвийн хүрээнд дарамт болохооргүй санхүүжилт. Сангийн яам мэдэж байгаа. 2026 оны төсөв хэлэлцэж байхад энийг ярьсан. 37 гишүүн гарын үсгээ зурж өгсөн. Одоо хөгжлийн төлөвлөгөө яригдана, төсөв яригдана. Тэгэхээр ирэх намар оруулж ирэхдээ Засгийн газар, Сангийн яам энийг заавал багтаахыг бодоорой. Тэгээд хувийн сургуулийн хүүхдүүд бол тэр төлбөртөө үдийн цайгаа багтаагаад, ямар ч асуудалгүй байгаа шүү дээ. Тэгээд улсын сургуульд явж байгаа хүүхдүүдээсээ 1 доллар хүрэхгүй мөнгийг хүүхдэдээ зориулж чадахгүй бол бид энд төсөв яриад бас яах вэ дээ. Тийм ээ. Тэгээд энэ бол олон улсын судалгаагаар маш сайн сурлагад нь нөлөөлдөг, анги дэвших шалгалтад нөлөөлдөг, том болоод бүр орлогод нь нөлөөлдөг гэсэн ийм мэдээж өсөлт хөгжилт бол 1 номер байгаа. Тэгээд энийг бас өнөөдөр хэлэлцэж байгаа асуудал дээр дахин сануулъя.

Тэгээд 3 сарын дараагаас эхлээд төсвөө хэлэлцэж эхэлнэ. Бас энэ дээр яг оруулж ирэхдээ энэ 37 гишүүнийг хүндэтгээд, өнгөрсөн Улсын Их Хурал дээр бас амласан амлалтаа тэр тогтоолд оруулна гээд бас оруулаагүй бас л хуурсан байна лээ. Тэгээд энэ дээр онцгой анхаарахыг хүсье. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явна. 2 санал хураалттай. Гишүүд орж ирээрэй. Ирцдээ орсон гишүүд 39 хүн ирсэн байна. Одоо энэ танхимд хэд байна. Санал хураалтдаа бэлтгээрэй гишүүд. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Хүрэхээргүй байна даа. Гишүүдийг дуудъя. Ажлын албаныхан гишүүдээ танхимд оруулж ирээрэй. 16 хүн байна шүү дээ 39-өөс. Энхцэцэг гишүүн сая санал хураалтад орсон уу. Заяабал гишүүнийх эсрэг гарсан байна. Сая Энхцэцэг гишүүнийх эсрэг гарсан байна. Хуруугаа уншуулчих. Сайнзориг гишүүн байхгүй байна. Дахиад бүртгэлийн санал хураалт явуулах уу. Бүртгэлийн санал хураалт. 18 гишүүн. 2 хүнээр нэмэгдсэн байна. Өөр хэн дутуу байна. Ганбаатар гишүүнийх эсрэг гарч байх юм. Мандхай гишүүн байхгүй байна. Танхимд 22 хүн байна шүү дээ уг нь. Дахиад бүртгэлийн санал хураалт явуулъя. Одоо санал хураалт явуулна. Санал хураалтын томъёоллыг уншиж өгье.

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. Энхбаяр санал хураалтад орох билүү. Санал хураалт. Гишүүд ээ, анхааралтай. 39 хүнээс 20 хүн дэмжиж, 51,3 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ чинь 39 хүнээс 19 хүн дэмжиж, 48,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тодотгол харин зайлшгүй хийх шаардлагатай байгаа шүү дээ. Гишүүд анхааралтай. Горимын санал гаргах хүн байна уу. Батсуурь гишүүн. Соронзонболд гишүүн горимын санал гаргана.

**Л.Соронзонболд:** Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийг баталснаас хойш 3 сарын дараа дахиж төсвийн тодотгол орж болохгүй гэсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Тэгэхээр тэрийг хасах тухай санал орж ирсэн. Тэгэнгүүт одоо 2026 хүний төсөв дээр зайлшгүй тодотгол хийх ийм шаардлага байна гэдэг үндсэн

шалтгааныг тайлбарласан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөөч гэж горимын санал гаргаж байна.

**Н.Наранбаатар:** Гишүүд анхааралтай байгаарай. Соронзонболд гишүүн горимын санал гаргасан. Саяын санал хураалтыг хүчингүй болгох гэсэн горимын санал гаргасан. Техникийн асуудал байвал дахин санал хураалт явуулах юм байна шүү дээ. Техникийн саналаас бусдаар бол болохгүй юм байна. Техникийн саналаар л горимын санал гаргах юм байна. Горимын санал гаргах юм байна. Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Сая дарахад кноп ажиллаагүй тул дахин санал хурааж өгнө үү. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хурааж өгнө үү.

**Н.Наранбаатар:** Соронзонболд гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч гэсэн горимын санал гаргалаа. Саяын Соронзонболд гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 39 гишүүнээс 22 хүн дэмжиж, 56,4 хувиар дэмжлээ.

Одоо үндсэн санал хураалт. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 39 гишүүнээс 22 дэмжиж, 56,4 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Танилцуулах гишүүн байна уу. Санал, дүгнэлт унших гишүүн байна уу. Соронзонболд гишүүн санал, дүгнэлт танилцуулах уу. Сэддорж гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.37 цаг.

2 дахь асуудал.

**Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг хэлэлцье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Мэндсайхан Сангийн сайд, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.1-д “Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон бусад газрын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж нараас Засгийн газрын гадаад өр, зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээллийг авах хүсэлт гаргасны дагуу Сангийн сайдаас дээрх мэдээллийг бэлтгэж ирүүлснийг эрхлэх асуудлын харьяаллын дагуу хамтран хэлэлцэнэ. Мэдээллийг Сангийн сайд Мэндсайхан танилцуулна. 4 номерын микрофон.

**3.Мэндсайхан:** Төсвийн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудал болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш төслийн нийт 308 төсөл арга хэмжээнд 10,4 тэрбум ам.долларын төслийн зээлийн хэлэлцээр байгуулснаас өнөөдрийн байдлаар 6,1 тэрбум ам.доллартой тэмцэх хэмжээний хөрөнгийг ашиглаж, 4,3 тэрбум ам.доллар буюу 13,8 их наяд төгрөгийн ашиглаагүй үлдэгдэлтэй байна.

Нийт зээлийн хэлэлцээр байгуулсан гадаад төслийн зээлийн 23 хувийг АХБ, 17 хувийг БНЭУ, 15 хувийг Дэлхийн банк, үлдсэн 45 хувийг бусад 18 хөгжлийн түнш эзэлж байна.

Нийт авсан гадаад төслийн зээлийн 45 хувийг дэд бүтэц, 14 хувийг эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн салбарт 16 хувийг авч ашиглахаар гэрээ байгуулсан. Эдгээр эх үүсвэр нь эдийн засаг, эрчим хүч, зам тээвэр, нийтийн аж ахуй, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарын суурь хөгжлийг дэмжихэд чухал нэмэр оруулж байна.

Нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын төсөвт ирэх шууд ачааллыг бууруулж, дунд болон урт хугацаанд хөгжлийн суурийг тавих чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа хэдий ч 2011 оноос нэн хөнгөлөлттэй нөхцөл өөрчлөгдөж, Монгол Улс энгийн болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах болсон. Харин 2024 оноос эхлэн манай улс дунджаас дээгүүр орлоготой улс болсон тул арилжааны хөнгөлөлт нөхцөлтэй зээл авах боломжтой болж, зээлийн нөхцөл өөрчлөгдөж байна. Тухайлбал, АХБ-ны зээл софр нэмэх нь 0,6 болж нэмэгдээд байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 35,4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39,4 хувьтай тэнцэж байна. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ тогтмол буурч, богино болон дунд хугацааны хөтөлбөрийн төлбөрийн хуваарийг жигдлэн, өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг тууштай мөрдөж байгааг олон улсын байгууллагууд онцгойлон авч үзэж, Монгол Улсын зээлжих зэрэглэл нэмэгдсэн.

Өнөөдрийн байдлаар 2012 оноос эхлэн гэрээ хэлэлцээр нь байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан 21 их наяд төгрөгийн нийт амлалт дүн бүхий 74 төсөл хэрэгжиж байгаагаас 7,2 их наяд төгрөг буюу 34,3 хувийг санхүүжилтийг ашигласан. Үлдсэн 13,8 их наяд төгрөг буюу 65,7 хувь нь

ашиглагдаагүй байна. Мөн тус төслүүдийн 68,4 хувь буюу 52 төсөл хөнгөлөлттэй, 31,6 хувь буюу 22 төсөл нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр хэрэгжиж байгааг энд дурдах нь зүйтэй байна.

Улсын Их Хурлаас 2026 онд баталсан зээлийн ашиглалт болох 1,2 их наяд төгрөгийн ашиглалтад багтаан санхүүжүүлэх үүднээс төслүүдийг эрэмбэлж, хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийг болон энэ онд хэрэгжиж дуусах төслүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэх зарчмыг баримталж байна. 2026 оны санхүүжилтийн 26 хувийг зам тээвэр, 22 хувийг Улаанбаатар хотын дэд бүтэц, 11 хувийг эрчим хүч, 7 хувийг эрүүл мэнд, 4 хувийг боловсролын салбарт зарцуулахаар байна. Энэ онд нийт 3,1 их наяд төгрөгийн 18 төсөл хэрэгжиж дуусах бол нийт 2,7 их наяд төгрөгийн 7 төсөл хэрэгжүүлэх салбар чиглэлд шинээр хэрэгжиж эхлэхээр гэрээ хэлэлцээрийн шатанд байна.

Нийт зээлийн төслүүдийн 13,8 их наяд төгрөгийн ашиглагдаагүй үлдэгдлийн 89 хувь нь 2026-2029 онд хэрэгжиж дуусах гэрээ хэлэлцээртэй байгаа нь ирэх 3 жилд зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл бөгөөд зээлийн ашиглалтыг Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаанд багтаан хэрэгжүүлэхгүй тохиолдолд төслийн хугацаа, хойшлох, өртөг өсөх, хүүгийн бол болон үйлчилгээний зардал нэмэгдэх, улмаар хөрөнгө оруулалтын төслүүд хугацаанд ашиглалтад ороогүйгээс үүдэн нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр өгөөж саарах бодит эрсдэлийг бий болгож байна.

Нөгөө талдаа Улсын Их Хурлаар соёрхон баталсан гэрээ хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуульд зааснаар олон улсын гэрээнд хамаардаг бөгөөд энэ үүднээсээ олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улс, санхүүгийн байгууллагаас тогтмол хийдэг үнэлгээнд нөлөөлөх асуудал юм.

Өнөөдрийн төсвийн хязгаарлалттай нөхцөл байдлаас шалтгаалж гадаад зээлийн эх үүсвэртэй төслүүдийн гэрээний дагуу шаардлагатай санхүүжилтийн дүн дөнгөж 22 орчим хувийг улсын төсөвт тусгаж байгаа нь хэрэгжилтийн гол хүндрэл болж байна.

Нийт 13,8 их наяд төгрөгийн ашиглаагүй үлдэгдлийн 38 хувь нь газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэний УЦС-ын төслүүдийн үлдэгдэл байгаа юм. Хэрэв зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхгүйгээр энэ түвшин хэвээр үргэлжилбэл зарим төслийн хэрэгжилт дунджаар 5-10 жилээр хойшлох, зардал нэмэгдэх, өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх бодит эрсдэл үүссэн нь хэдийгээр энэ онд 18 төсөл хэрэгжиж дуусаж байгаа боловч шинээр эхлэх төслүүдийн гэрээтэй холбоотойгоор зээлийн ашиглаагүй үлдэгдэл ирэх онуудад ч өндөр хэвээр байх магадлалтай байна.

Иймд Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын олон эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох шаардлага үүссэн тул Засгийн газраас уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж яаралтай горимоор Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Мөн бид дээрх сорилтыг даван туулахын тулд төсвийн үр ашиг, шинэчлэлийн хүрээнд дараах санхүүжилтийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Санхүүжилтийг шилжүүлэх зээлийн төслүүдийн үр ашиг, ач холбогдлоор нь эрэмбэлж, 2025-2026 онуудад нийтдээ 327,9 тэрбум төгрөгийн зохицуулалтыг хийж, 42 төслийн хүрээнд 163 ажлыг хэсэгчлэн болон бүхлээр нь хойшлуулж, эдийн засгийн үр өгөөжтэй бусад төслүүдийн санхүүжилтэд шилжүүлж, гүйцэтгэлийн санхүүжилтийг удаашруулахгүй байх зохицуулалтыг хийсэн.

2. Хэмнэлтийн зарчим буюу нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлэх төсөл бүрд тусгайлан байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийг тогтолцооны хувьд шилжилт хийж, салбар бүрд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй болгож, 200 орчим орон тоог бууруулан нэгжийн урсгал зардлыг 39 хувь буюу 11,5 тэрбум төгрөгөөр бууруулж, хэмнэлт хийлээ.

3. Цахим шилжилтийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд гадаад зээл тусламжийн болон бусад эх үүсвэрийг нэгтгэх, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, гадаад зээл тусламжийн бүхий л үе шатыг олон нийтэд нээлттэй, ил тод болгох дэд системийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хүнээс хамааралтай техник, процессын үйл ажиллагааг бууруулж, цахимжуулах ажлыг яг үе шаттай хэрэгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Эдгээр арга хэмжээ нь зээлийн хөрөнгийг сахилга хариуцлагатай, илүү үр өгөөжтэй, бүтээмжтэй ашиглах тогтолцооны шинэчлэл юм. Мөн цаашид шинээр авах гадаад зээлийн төслүүдийг Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх бодлогын болон хууль зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Төсвийн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Цаашид Засгийн газраас гадаад зээлийн бодлогын эдийн засгийн өгөөж, төсвийн сахилга бат, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулж, Улсын Их Хуралтай хамтран шаардлагатай төсөв, санхүүгийн бодлого, эрх зүйн шинэчлэлийг тууштай хэрэгжүүлэн ажиллах болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Н.Наранбаатар:** Мэндсайхан сайд баярлалаа. Сангийн сайдын мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Дараа нь үг байгаа. Бадамсүрэн гишүүнээр, Жаргалсайхан гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Энэ гадаад зээлийн ашиглалт дээр ерөнхийдөө 98 төсөл байна гээд тайлан дээр байгаад байдаг. Жагсаалтаар бол 76 төслийн тухай мэдээлэл байгаад байна. Тэгээд 22 төслийнх нь зөрүү нь ямар төслүүд байгаа юм бэ. Энэ талаар мэдээлэл 1 дүгээрт.

2 дугаарт бол төслийн нэгдсэн нэгж байгуулж, энэ 200 гаруй орон тоогоор бууруулж ажилласан. Энэ маш сайн жишиг болсон байна. Ер нь цаашдаа ялангуяа Сангийн яамны хувьд бол нэг чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүмүүсийн ажлын байрны зураг авалт хийх талаар, зардал бууруулах талаар ямар ажлууд хийж байна вэ гэдэг асуулт.

Дараа нь болохоор бол урсгал зардал санхүүжүүлсэн хувь нь бол 40 хэдэн хувьтай гээд энэ тайлан дээр гарсан байх шиг байсан. Тэгэхээр ер нь цаашдаа энэ тал дээр тодорхой яг ямар саналууд байгаа вэ гэсэн ийм санал асуулт байна.

**Н.Наранбаатар:** 4 номер Сангийн сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Нийтдээ 98 төсөл байгаа. Тэрний 74 гаднын зээлээр, 24 нь буцалтгүй тусламж байгаа. Тэгээд нийт төслийнхөө тоогоор 98 болж харагдаад байгаа. Соронзонболд гишүүн ээ тодруулаад асуучих уу. Тэр нөгөө урсгал зардал юу гэххэв.

**Н.Наранбаатар:** Соронзонболд гишүүн тодруулна.

**Л.Соронзонболд:** Тайлан дээр болохоор бол энэ төслүүдийн маань зориулалтын 50 гаруй хувь нь болохоор илүү дэд бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлтэй байна. Үлдсэн 40 гаруй хувь нь болохоор нөгөө зөвлөх үйлчилгээ, тэгээд шууд зардалтай холбоотой зарцуулагдсан юм байна гэсэн ийм тайлан гарсан байсан. Тэрнээс асуугаад байгаа юм.

**Н.Наранбаатар:** 4 номер.

**З.Мэндсайхан:** Энэ дээр Соронзонболд гишүүн ээ, зөвлөх үйлчилгээний төслүүд маань урсгал зардал дээр явж байгаа. Яг одоо яригдаж байгаа энэ 98 төслийн 74 нь гадаадын зээл буюу бид нарын авсан хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлүүд явж байгаа. 24 нь буцалтгүй тусламж байгаа. Тэгэхээр энэ гаднын зээлээр бол бид нар урсгал зардал санхүүжүүлж байгаа асуудал байхгүй. Хуулиараа зөвхөн төсөл хөтөлбөрт зарцуулагдаж байгаа.

**Н.Наранбаатар:** Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

**М.Бадамсүрэн:** Энэ гадаад зээл дотор хамгийн том дүн эзэлж байгаа нь газрын тос боловсруулах үйлдвэр байгаа. Бараг дамжуулах хоолойтойгоо 6, 7 их наяд төгрөг байна уу даа. Тэгээд энд Аж үйлдвэрийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сард 1 тогтоол гаргасан юм. Тэгээд одоо Аж үйлдвэрийн байнгын хорооны эрхлэх асуудал чинь Эдийн засгийн байнгын хороонд ирчихсэн байгаа. Үүний гол утга бол 1 дүгээрт төслийн хэрэгжилтийн явцыг жил бүр төсвийн гүйцэтгэлтэй хамт танилцуулж байх гээд. Тэгээд энийг энэ 2026 оны төсвийн гүйцэтгэлтэй хамт холбогдох Байнгын хороонд танилцуулах талаар ямар нэгэн мэдээлэл, тэр Байнгын хорооны тогтоолыг авсан байгаа юу.

2 дугаарт нь энэ төсөл дээр дахиад нэмж 1 ч төгрөгийн зээл авахгүй, дахиад хугацаа сунгахгүй гэдэг ийм даалгавар өгсөн тогтоол байгаа.

3 дугаарт нь түүхий тосны дотоодын нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой. Энийг бол үйлдвэр 2028 оны 1 дүгээр улиралд ашиглалтад ороход түүхий тосны дотоодын нөөцийг бүрэн бүрдүүлсэн байх гэдэг. Энэ чиглэлээр Сангийн яаманд хамааралгүй байх. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас холбогдох албан тушаалтан байгаа бол эсвэл энэ талаар мэдээлэл байгаа бол энэ талаар ер нь яг юу хийгдэж байгаа юм бол. Яах вэ, миний хувьд санаа зовоод байгаа юм нь ингээд үйлдвэр маань ашиглалтад ордог. Түүхий тосгүй болчих вий. Тэгээд сүүний үйлдвэрээр бодох юм бол үнээгээ өөрсдөө бид нар сааж чадахгүй байгаа. Дандаа гаднын компани тос олборлож байна. Тэгэхээр үндэсний хөрөнгө оруулалттай ийм төрийн өмчит газрын

тос боловсруулах үйлдвэр байгуулагдаж байгаа учраас төрийн өмчит хайгуул, олборлолтын үйл ажиллагааг явуулахгүй бол түүхий эдийн хувьд хараат байдалд, түүхий эдийн хувьд бол нөөцгүй байдалд орох гээд байгаа юм. Тэгээд энэ талаар санаа зовниж байна. Тийм учраас гадаад зээлийн хамгийн том хэсэг болох газрын тосны үйлдвэрийн яг мөн чанар нь бол мөнгөнөөсөө гадна энэ үйл ажиллагаатай холбоотой зүйл байгаа юм. Яах вэ, Сангийн яам бол санхүүжилттэй холбоотой зүйлийг нь л хариуцаж байгаа. Гэхдээ энийг гүйцэтгэлийнх нь явцыг төсвийн гүйцэтгэлтэй хамт төсвийн гүйцэтгэл дээр заавал оруулж ирээрэй. Тэгээд энийг бүр албан ёсоор сануулж та бүхэндээ хэлье. Тэгээд энэ дээр бас холбогдох хариултыг авъя. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Сангийн сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тантай санал нэг байгаа. Энэ 2028 онд энд төслийг ашиглалтад оруулах, төсөвт өртгийг дахиж нэмэхгүй байх чиглэл дээр энэ утгаар нь Эрдэнэбүрэн, газрын тос дээр сая манай Алтаншагай тэргүүтэй гишүүдийн өргөн барьсан хууль Их Хурал дээр унасан. Тэгэхээр бид нар Засгийн газраас энэ хуулийг зөвхөн газрын тос, Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг гадаад зээлийн төсвийн хязгаараас гаргая гэдэг хуулийн төслийг маргааш Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, ойрын хугацаанд нэн яаралтай Их Хурлаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Төсвийн гадаад зээлийн гүйцэтгэлийн тусламж, гадаад зээл, тусламжийн хэрэгжилт, гүйцэтгэлийн тайланг бол жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаад явна. Энэ 2025 оны гүйцэтгэлийг бол төсөв өргөн барихдаа энэ оны юун дээр тусгайлан оруулж ирнэ.

Газрын тосны түүхий эдийн хангамжтай холбоотой асуудлыг би Дамдинням сайдад уламжилж, танд албан ёсоор бичгээр тайлбар хүргүүлэх талаар хэлье.

**Н.Наранбаатар:** Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

**Д.Жаргалсайхан:** Энэ гадаад зээлийг ашиглах нь бол зөв. Тэгээд ашиглахдаа хэдүүлээ бас эрэмбэ дараатай ашигламаар байна. Тэр тусмаа импортын бараа бүтээгдэхүүнийг орлох яг хэдэн төсөл байгаа юм. Тэгээд үр өгөөж нь бас эрэмбэлсэн тоо баримтууд байна уу. 1 дэх асуудал.

Дараа нь хэд нь эхэлсэн байгаа юм. Ер нь энэ олон төслүүдээс. Тэгээд эхэлж чадахгүй байгаа нь хэд байгаа юм. Яг ямар учир, шалтгаан байгаа юм. Тэр тусмаа энэ төсөв нэмэгддэг асуудал байгаад байна. Тэгээд энэ төсөв ер нь ганцхан гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар гэхээсээ илүүтэй ер нь л ингээд л төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлууд ч гэсэн тэр. Төсөв бол ингээд ямар ч үндэслэлгүйгээр, эсвэл харилцан адилгүйгээр нэмэгддэг. Бүр өмнөх жилүүдэд Хэнтий аймгийн 1км зам бол 3, 4 тэрбум байлаа шүү дээ. Тэгэхэд баруун аймгуудынх бол 1,2, 1,3-тай гээд л. Тэгээд би өөрөө бол энэ авто зам, төмөр замын л мэргэжлийн байгууллагад ажиллаж байсан л хүн л дээ. Тэгтэл 1 ийм юм хийгээд байгаа нь ямар учиртай юм. Тэгээд энэ дээр Барилга хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв энэ хүмүүст хариуцлага тооцох ямар асуудал байна. Энэ дээр ямар ахиц дэвшил гарч байгаа юм. Та энэ дээр хариулт өгөөч.

Тэгээд тэр тусмаа гадаадын зээлээр нь хийгдэж байгаа ажил, үйлчилгээнүүд байнгын л өртөг зардал нь маш их нэмэгддэг. Бараг энэ улсын төсөвт хамаагүй юм

шиг ийм ойлголтыг төрүүлээд байна л даа. Энэ бол маш их хамаатай асуудал шүү дээ. Тэгээд энэ зүйлүүд дээр та 1 тоо баримтууд хэлж өгөөч.

**Н.Наранбаатар:** Сангийн сайд хариулна.

**З.Мэндсайхан:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Өрийн удирдлагын тухай хуулиараа ч тэр эдийн засгийн ашиг өгөөжөөр нь эрэмбэлж байгаа. Нөгөө талдаа зээл олгож байгаа донор байгууллагууд маань өөрсдөө бас энэ төслөө эрэмбэлээд явж байгаа. Тэгээд бид нар өрийн удирдлагын тухай хуулиараа эдийн засгийн өгөөж, үр ашгаар нь эрэмбэлээд оруулж ирж байгаа энэ асуудлыг Их Хурлаар тухайн төслийг баталж байгаа. Тэгэхээр энэ төсөвт өртөг өсөх асуудал бол энэ чинь санхүүжүүлэгч донор байгууллагууд маань давхар бас хяналт, манай дотоод хяналтаас гадна тэд бас хяналтаа тавиад явж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар Сангийн яам үнэ өртөг өсөх ийм асуудал бол байхгүй ээ.

**Н.Наранбаатар:** Жавхлан гишүүн асуулт асууна. Байж байгаарай. Жаргалсайхан гишүүн тодруулъя.

**Д.Жаргалсайхан:** Дутуу хариулж байна л даа. Хэд нь эхэлсэн, хэд нь эхлээгүй гээд энэ төслүүд дээр зөндөө тоо ярилаа шүү дээ. Энэ тоог хэлээд өгчих.

Дараа нь би бол сая ганцхан гадаадын зээл биш, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил, үйлчилгээнүүд дээр харилцан адилгүй. Жишээ нь манай Үүрийнтуяа гишүүн сууж байна л даа. Төсөв нь нэмэгдчихдэг. Ямар ч үндэслэлгүйгээр нэмэгддэг. Тэгээд энэ дээр хуулийн төсөл санаачилна гээд явж байсан байх. Тэгээд энэ дээр та юу хийж байна. Жилийн жилд ийм юм ярьдаг. Энэ 2-ыг 1 тодорхой хэлж өгөөч.

**Н.Наранбаатар:** Сангийн сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Гаднын зээлээр хэрэгжиж байгаа төслүүд бол Их Хурлаар соёрхон баталсан зээлийн үнийн дүнд багтаад л хэрэгжээд явж байгаа. Дотоодын хөрөнгө оруулалтын асуудал бол Барилгын тухай хуулиараа магадлан хийгээд, төсөвт өртөг өсөж байгаа асуудал байгаа. Энэ дээр бол бид нар тэр холбогдох мэргэжлийн байгууллагуудын хийсэн магадлан дээр үндэслэж төсөв өртөг нэмэгдсэн ийм тохиолдлууд бол байгаа. Ер нь бол гаднын зээлээр хэрэгжээгүй төсөл одоо бол байхгүй. 74 төсөл хэрэгжээд явж байгаа. 24 буцалтгүй тусламжийн төсөл гээд нийт 98 төсөл хөтөлбөр хэрэгжээд явж байна.

**Н.Наранбаатар:** Жаргалсайхан гишүүн тодруулъя.

**Д.Жаргалсайхан:** Манайхан ингээд тэр тусмаа томоохон дүнтэй төсөл тендерүүд дээр оролцох гэхээр аймар олон улсын шаардлага тавьчихаж байгаа юм. Тэгээд Монголын аж ахуйн нэгжүүд орж чаддаггүй. Тэгээд л гаднын нэр барьсан компани ирээд, тэгээд л монголчуудыг баахан туслангаар авах, тэр өртөг зардал нь ч маш бага. Тэгээд тэрнээсээ авхуулаад бөөн чанаргүй ажлууд хийгддэг. Энэ дээр ер нь манай энэ Сангийн яам ямар байдалтай оролцож байна. Зээл дээр эргээд бид нар дотоодынхоо аж ахуйн нэгжийг оролцуулмаар байна шүү дээ. Энэ дээр ямар бодлого, үйл ажиллагаа явж байна. Энэ дээр ямар санал, санаачилга гарч байна.

**Н.Наранбаатар:** Хариулъя. Сангийн сайд.

**З.Мэндсайхан:** Энэ зээлийн хэлэлцээр дээр Жаргалсайхан гишүүн ээ, АХБ, Дэлхийн банк ч гэдэг юм уу эдгээр байгууллагуудад маань өгч байгаа зээлийнхээ сонгон шалгаруулалт нь тэр байгууллагуудын дүрмээр явж байгаа. Манай тендерийн хуулиар явдаггүй.

**Н.Наранбаатар:** Дууссан. 2 л тодруулна шүү дээ. Дэгээрээ 2 удаа асуугаад, 2 тодруулаад, тэгээд цаашаа асуулт байвал бичгээр хариулт өгнө шүү. Сангийн сангийн яам бичгээр хариулт өгөөрэй Жаргалсайхан гишүүнд. Одоо Жавхлан гишүүн асуулт асууна байна.

**Б.Жавхлан:** Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе. Би 1 асуулт асууя гэж бодож байсан. Сая Мэндсайхан сайд мэдээлэл өгчихлөө дөө. Засгийн газар эргүүлж хуулиа яаралтайгаар оруулж ирэх юм байна. Сая харамсалтай зүйл болсон. Өнгөрсөн 5 дахь өдрийн хурлаар нэр бүхий гишүүд Аубакир гишүүн, Ганхуяг гишүүдийн өргөн барьсан энэ хуулийг Их Хурал дэмжээгүй. Ёстой амандаа орсон шар тосыг түлхэв гэдэг шиг л болсон. Гэхдээ тэр жагсаалтад учир байна л гэж ойлгосон. Тэр зээлүүдийн. Тэрнээс биш тэр Эрдэнэбүрэнгийн УЦС, нефть боловсруулах үйлдвэр, Сэлбийн төсөл, энэ 3 төсөл чинь нийлээд Засгийн газрын гадаад зээлийн бараг 40 гаруй хувь нь байгаа байх. Тийм ээ. 98 төслийн ерөөсөө 3 төсөл нь энэ 3 төсөл ерөөсөө нийт зээлийн 40 гаруй хувь нь байгаа байхгүй юу. Тэгээд манайх шиг ингэж ийм хоцрогдсон төсвийн бүртгэлтэй улс ООС-ийн гишүүн орнууд дээр маш цөөхөн үлдэж байгаа. Маш яаралтайгаар бид нар энэ JFS 13 гээд дэлхийн улс орнуудын бараг дийлэнх нь шинэ энэ төсвийн бүртгэлийн систем рүүгээ шилжчихсэн. Энэ рүүгээ яаралтай шилжих хэрэгтэй ийм ажлаа яаралтай ажил болгож явуулах хэрэгтэй. Ер нь бол эхлэл нь тавигдчихсан байгаа. 5 дахь өдрийн хуралдаан дээр би өөрөө хариуцлага алдаж, яг хуралдаан эхлэнгүүтээ санал, асуулт явчихсан. Тэр дээр би хоцорч орж ирээд санал өгч чадаагүй. Уучлаарай. Одоо Засгийн газар энийг хэрвээ ингээд яаралтайгаар өргөн бариад явах юм бол дэмжээд, хэрвээ ажлын хэсэг байгуулагдах юм бол би хүсэлтээр энэ ажлын хэсгийг нь ахлаад, энэ хуулийг яаралтайгаар батлуулах ийм саналтай байгаа шүү. Энийг Төсвийн байнгын хороон даргадаа уламжилчихъя. Тэгээд цаг алдалгүй энэ хуулиа өргөн бариарай. Энэ жил нефть боловсруулах үйлдвэрийн төсөл маш сайн явж байгаа. 2028 оны 2 дугаар улирал гэж байгаа боловч гүйцэтгэгч компаниуд хэрвээ танай санхүүжилт чинь саатахгүй бол, санхүүжилт гэдэг нь бид нарын өгсөн зээл гэж ярьж байгаа шүү. Бид нарын өгсөн зээлийг та нар саадгүй бид нарт дамжуулаад байх юм бол 2028 оны 2 дугаар улирал биш, 2028 оны 1 дүгээр улирал, бүр шахвал 2027 ондоо багтаагаад ашиглалтад өгөх ийм ажлын графиктай явж байгаа шүү гэдгээ илэрхийлсэн байдаг.

Тэгээд Засгийн газар яг өөрсдийн яг бодлого болоод энэ хуулиа ороод ирэхээр энийг бас өргөн хэлэлцүүлэг болгоод, олон нийтэд их зөв ойлгуулах хэрэгтэй байгаа юм. Энэ чинь тийм бодлогын бөгөөд бодлого дотроо энэ чинь ерөөсөө яг төсвийн бүртгэлийн асуудал байгаа байхгүй юу. Бүртгэлийн асуудал. Айл өрх зээл авчхаад, 1 Түц барих гээд, тэгээд зээлээ ашиглах гэхээр тэрийгээ өрх гэрийнхээ алдагдалд тооцдоггүй биз дээ.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Өдрийн мэнд хүргэе. Гадаад зээлийн ашиглалттай холбоотой асуудлыг Их Хуралд сонгогдсоноосоо хойш л санаа тавиад яваад байгаа. Зүгээр ашиглалттай нь холбоотой асуудал шүү. Тэгээд саяын орж ирсэн хуулийн төсөл чинь ер нь бол тэр төслөөсөө болоод уначихсан гэж хараад байгаа юм. Мэдээж бид

нар нефтийн үйлдвэртэй болох хэрэгтэй байгаад байгаа. Эрдэнэбүрээний цахилгаан станц явах уу, явах хэрэгтэй. Энэ 2-ыг дэмжээд явж байсан. Байнгын хороо дээр ч гэсэн Сэлбэ гэдэг дэд төвийн асуудал ороод ирсэн. Байнгын хороо дээр эд нарыг хасчихсан гэж ярьсаар байгаад Их Хурал дээр босгоод оруулаад ирчихсэн. Үүнээс болоод л уначихсан гэж хараад байгаа юм. Тэгэхээр Засаг энийг хурдан хугацаанд энэ 2 төслийнхөө асуудал дээр бас хуулиа дахин өргөн барих хэрэгтэй байх. Жавхлан гишүүнтэй бас санал нэг байна. Өргөөд ороод ирэх юм бол мэдээж ажиллахад бэлэн байна.

Хамгийн гол 1 зүйл яримаар байгаа юм. Түрүүн бас Жаргалсайхан гишүүн дурдаад байх шиг байна. Энэ гадаад зээл авчхаад бид нар яг тэр зээлээ бүр барагдуулж дуусах ёстой юм шиг тухайн төсөлдөө шингээх гээд яваад байдаг. Энэ нь өөрсдөө манай нөгөө дотоодын хийгээд байгаа, дотоодод боловсруулаад байгаа төсөвт өртгөөс өндөр болчихоод байдаг. Ажлынх нь төсөвт өртгүүд байнга. Тэгэхээр энэ дээр анхаарч ажиллаач ээ гээд би санал хэлээд байгаа. Сангийн яам бас энэ дээрээ анхаарч ажиллаад өгөөч ээ. Үлдэж байгаа бас одоо бид нар чинь энийг дахиад гадаад зээлийн хууль орж ирээд, батлагдаад гарлаа гэж бодоход дахиад цаана нь 7, 8 их наядын асуудал үлдээд байгаа. Энийгээ бид нар бас яаж ашиглах юм. Саяын Жавхлан гишүүний хэлээд байгаа тэр бүртгэлдээ яаж тусгах юм. Энийгээ ер нь нэг мөр шийдээд, нийтдээ бид нарын ашиглаж чадахгүй байгаа тэр 13,4 байгаа билүү, 7 билүү энийгээ ашиглах ашиглах тал руугаа Сангийн яам анхаарч ажиллаач гэж. Үлдсэн 7, 8 үлдээд байгаа шүү дээ. Энийгээ ч гэсэндээ бас ер нь оруулж ирээд бушуухан ашигламаар байна. Ийм л саналтай байна.

**Н.Наранбаатар:** Санал хэлчихлээ. Гишүүд үг хэлж дууслаа. Үг хэлж, асуулт асууж дууслаа.

Засгийн газрын гадаад зээл тусламжийн төслийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаарх Сангийн сайдын мэдээллийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж дууслаа.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

13.03 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*